

Mongolia Grow with Google


2024-2026

НӨЛӨӨЛЛИЙН ТАЙЛАН



1,000+

залуусын эзэмшсэн ур чадвар,
амьдралд нь бий болсон үр дүн



Mongolia
Grow with Google



ӨМНӨХ ҮГ

Бидний ажиллах, суралцах, бүтээх арга барил урьд өмнөхөөсөө илүү хурдтай өөрчлөгдөж, хиймэл оюун ухаан болон дижитал шилжилт нь технологийн томоохон хувьсгал төдийгүй, дэлхий даяар ур чадварын шинэ эрин үеийг эхлүүлээд байна. Ирээдүйн боломжууд улам бүр практик чадварт суурилах болсон энэ үед чанартай боловсрол, олон улсын түвшний мэдлэгийг хүртээмжтэй хүргэх нь манай багийн өмнө тулгарсан хамгийн чухал зорилт байв.

Энэхүү цаг үеийн шаардлага, хүлээлтийн дундаас дэлхийн түвшний чанартай боловсролыг Монголын залууст хамгийн хүртээмжтэйгээр хүргэх алсын хараа маань төрж, бид "Grow with Google Mongolia" санаачилгыг анх эхлүүлж байв. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөрүүдийг эх орондоо нутагшуулж, залуус, мэргэжилтнүүд болон бизнес эрхлэгчдэд карьераа ахиулах, бизнесээ өргөжүүлэх бодит хөшүүрэг болохыг бид зорьсон билээ.

2023 оноос эхэлсэн энэхүү аялал маань өнөөдөр сургалтын хүрээнээс хальж, төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудыг нэгтгэсэн, Монголын хамгийн идэвхтэй дижитал ур чадварын экосистем болон өргөжжээ.

Энэхүү тайланд бид хамтын хүчин чармайлтын үр дүнд бий болсон бодит нөлөө, хэмжигдэхүйц үр дүнгүүдийг нэгтгэн танилцуулж байна. Үүнд:

- 1,125 суралцагч дэлхийн жишигт нийцсэн нарийн мэргэжлийн хөтөлбөрүүдийг амжилттай дүүргэв.
- Монголын хөдөлмөрийн зах зээлд нэн шаардлагатай байгаа дата аналитик, төслийн менежмент, хиймэл оюун ухааны хэрэглээний ур чадваруудыг бодитоор нутагшууллаа.
- Олон зуун залуус карьераа шинээр эхлүүлж, орлогоо нэмэгдүүлэн, тэдний ажил эрхлэлтэд бодит ахиц гарлаа.

Энэхүү нөлөөллийн тайлангийн хуудас бүрийн ард хуурай тоо баримтаас илүүтэй өөрийнхөө болон эх орныхоо ирээдүйг өөрчлөхөөр зориг шулуудсан олон зуун суралцагчдын маань хичээл зүтгэл, амжилтын түүхүүд дурайж байгаа. Энэ бол монгол залууст боломж, зөв хөтөч нь байвал дэлхийн хэмжээний мэдлэгийг эзэмшиж, хаана ч өрсөлдөх чадвартайг харуулсан хамгийн том нотолгоо юм.



Бидний итгэл үнэмшил энгийн. Ур чадвартай иргэн бол өрсөлдөх чадвартай эдийн засгийн үндэс, харин боломжийг өөртөө бий болгож чаддаг залуус бол улсын ирээдүйн хамгийн үнэт хөрөнгө юм. Тиймээс “Grow with Google Mongolia” нь сургалтын хөтөлбөр гэхээсээ илүү Монголын ирээдүйн хүний капиталд хийж буй урт хугацааны хөрөнгө оруулалт хэмээн бид үздэг. Бид илүү олон хүнд шинэ боломжийн үүдийг нээхийн тулд цаашид ч тууштай ажиллах болно.

2023 онд эхэлсэн жижиг санаачилга өнөөдөр 1,125 суралцагчийн хамтын хөдөлгөөн болж өргөжсөн нь миний хувьд хамгийн том бахархал юм. Энэхүү түүхийг хамтдаа бүтээлцэж буй чин сэтгэлт багш нар, менторууд, дэмжин ажилласан түнш байгууллагууд, ивээн тэтгэгчид болон эрдмийн аянд түүчээлсэн нийт суралцагчдадаа гүн талархал илэрхийлье.



Б.Тэмүүлэн

"Grow with Google Mongolia" төслийн санаачлагч



МОНГОЛ УЛСЫН УР ЧАДВАРЫН ШИЛЖИЛТИЙН БОДЛОГО, ШИНЖИЛГЭЭ

Хөдөлмөрийн зах зээл, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт ба дахин ур чадваржуулах буюу “upskilling / reskilling”-ийн үүрэг

Сүүлийн жилүүдэд дэлхийн эдийн засаг технологид суурилсан, мэдлэг төвтэй бүтцэд хурдацтай шилжиж байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн шаардлагыг үндсээр нь өөрчилж байна. Монгол Улсын хувьд энэ өөрчлөлт нь дан ганц боловсролын салбарын асуудал бус, эдийн засгийн бүтцийн гүнзгий сорилт болж хувирсан. 2024-2026 оны бодит өгөгдөл, хөдөлмөрийн зах зээлийн динамик, ажил олгогчдын зан төлөв, сургалтын зах зээлийн өөрчлөлтүүдийг нэгтгэн үзвэл Монгол Улсад ур чадварын шилжилт (skills transition) нь эдийн засгийн өсөлтийн дараагийн шатны гол хөшүүрэг болох нь тодорхой байгаа юм.

Энэ үүднээс авч үзвэл юуны өмнө хөдөлмөрийн бүтээмжийн асуудал Монголын эдийн засгийн төв зангилаа хэвээр байна. Нэг ажилтанд ногдох нэмүү өртөг өндөр орлоготой орнуудтай харьцуулахад хэд дахин бага түвшинд байгаа нь капиталын хомсдол гэхээс илүү хүний капиталын чанар, ур чадварын бүтэцтэй илүү холбоотойг олон улсын болон дотоодын судалгаанууд харуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл, хүний хөгжлийн индексийн дэд үзүүлэлтүүд, тэр дундаа боловсролын чанар, эзэмшсэн чадварын бодит хэрэглээ хоёрын зөрүү хөдөлмөрийн зах зээлд шууд тусгалаа олж байна.




Эх сурвалж: 1212.mn – ҮСХ (2024); ХНХЯ – Хөдөлмөрийн зах зээлийн тайлан (2023–2025)

Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүдийг авч үзвэл 2024 оны байдлаар нийт ажиллах хүч ойролцоогоор 1.3 сая орчимд хэлбэлзэж, ажилгүйдлийн түвшин 6-7 хувийн хооронд хадгалагдаж байна. Гэвч энэ дундаж үзүүлэлт бодит нөхцөл байдлыг бүрэн илэрхийлэхгүй. Залуучуудын ажилгүйдэл энэ дундаж түвшнээс мэдэгдэхүйц өндөр, харин албан бус хөдөлмөр эрхлэлт өндөр хэвээр байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн чанарын асуудлыг тодотгож байгаа юм. Нөгөө талаас ажил олгогчдын дунд хийсэн судалгаагаар шаардлагатай ур чадвартай ажилтан олдохгүй байгаа тухай гомдол 60 хувиас давсан нь ажилгүйдэл болон ажиллах хүчний хомсдол зэрэгцэн оршиж буйг илтгэнэ.

01 · ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ

Салбарын ажиллах хүчний хуваарилалт ба бүтээмжийн зөрүү



Эх сурвалж: 1212.mn - ҮСХ, Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд (2024); ХНХЯ (2023-2025)

Салбарын бүтцийн хувьд Монгол Улсын эдийн засагт уул уурхайн салбар бага хэмжээний ажиллах хүч шингээдэг атлаа ДНБ-д өндөр хувь эзэлж, харин үйлчилгээ болон хөдөө аж ахуйн салбарууд харьцангуй бага бүтээмжтэй боловч ихэнх ажиллах хүчийг шингээж байна. Энэ нь хөдөлмөрийн нөөц өндөр бүтээмжтэй салбар руу шилжиж чадахгүй байгаагийн илрэл бөгөөд ийм шилжилтийг зөвхөн ур чадварын шинэчлэлээр дамжуулан хэрэгжүүлэх боломжтой.

Хөдөлмөрийн зах зээлийн бодит цагийн дохиог онлайн платформуудын өгөгдөл илүү тодорхой харуулна. Zangia.mn болон Worki.mn зэрэг платформуудын 2024-2025 оны агрегат мэдээллээс харахад мэдээллийн технологи, өгөгдлийн шинжилгээ, дижитал маркетинг зэрэг чиглэлийн ажлын байрны эрэлт уламжлалт мэргэжлүүдээс 2-3 дахин хурдтай өсөж байна. Эдгээр ажлын байрны цалин зах зээлийн дунджаас дунджаар 1.8-2.5 дахин өндөр байгаа нь ур чадварын ялгаа орлогын ялгааг шууд тодорхойлж эхэлснийг илтгэнэ. Түүнчлэн англи хэл болон дижитал ур чадварыг зэрэг шаардсан ажлын байр нийт зарлагдсан ажлын байрны гуравны нэгээс давж байгаа нь Монголын хөдөлмөрийн зах зээл аажмаар олон улсын зах зээлтэй уялдаж байгааг харуулж байгаа юм.

02 · УР ЧАДВАРЫН ЗӨРҮҮ

Ажил олгогчдын ур чадварын шаардлага ба нийлүүлэлт хоорондын ялгаа



Эх сурвалж: Zangia.mn, Worki.mn – Онлайн хөдөлмөрийн зах зээлийн агрегат мэдээлэл (2024-2025)

03 · ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН БОДИТ ЦАГИЙН ДОХИО

Ажлын байрны эрэлт ба цалингийн индекс (2024–2025)




Эх сурвалж: Zangia.mn, Worki.mn - Онлайн хөдөлмөрийн зах зээлийн агрегат мэдээлэл (2024–2025)

Сургалтын зах зээлийн өөрчлөлтүүд ч мөн адил тодорхой дохио өгч байна. Lambda.mn зэрэг платформуудын мэдээллээр сүүлийн 2-3 жилд програмчлал, өгөгдлийн шинжилгээ, UX дизайн чиглэлийн сургалтын элсэлт хоёр дахин өссөн бөгөөд суралцагчдын дийлэнх нь анхны мэргэжлээсээ өөр чиглэлд шилжих зорилготой байна. Энэ нь Монголд насанд хүрэгчдийн дахин ур чадваржих (reskilling) бодит эрэлт аль хэдийн бий болсныг харуулна. Энэхүү тоон үзүүлэлтийг насны бүтцээр нь авч үзвэл 25-35 насныхан зонхилж байгаа нь хөдөлмөрийн идэвхтэй хэсэг өөрсдийгөө дахин бэлтгэх шаардлагыг ойлгож эхэлснийг илтгэж байна.

Гэсэн хэдий ч энэхүү шилжилтийг дэмжих институцийн орчин хангалтгүй хэвээр байгаа бөгөөд боловсролын системийн шинэчлэл хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтийн хурдаас хоцорч байна. Тодруулбал, их, дээд сургуулийн хөтөлбөрийн шинэчлэлийн мөчлөг дунджаар 3-5 жил үргэлжилдэг бол цахим шилжилт салбаруудад нэвчиж, хөгжлийн түшинг тодорхойлдог болсон энэ үед технологийн хөгжил 1-2 жилийн дотор эрчимтэй хувьсаж байгаа юм. Үүний үр дүнд төгсөгчдийн мэдлэг зах зээлийн бодит шаардлагаас хоцрох бүтэц үүсдэг. Нөгөө талаас насанд хүрэгчдийн сургалтын санхүүжилтийн тогтолцоо болон ажил олгогчдын сургалтын хөрөнгө оруулалт бусад улс орнуудтай харьцуулахад хязгаарлагдмал байгаа нь ур чадварын хөрөнгө оруулалтыг хувь хүний эрсдэл болгож байна гэсэн үг.

05 · ИНСТИТУЦИЙН ОРЧНЫ ХОЦРОГДОЛ

Боловсролын системийн шинэчлэлийн хурд ба технологийн өөрчлөлтийн харьцаа



Эх сурвалж: БШУЯ – Боловсролын салбарын статистик, үр чадварын тайлан (2024);
WEF – Future of Jobs Report (2023, 2025)

Үүнээс гадна мэдээллийн асимметри буюу тэнцвэргүй байдал мөн томоохон асуудал хэвээр байсаар байна. Иргэд ямар үр чадвар эрэлттэй байгаа талаар системтэй мэдээлэл авч чаддаггүй, харин ажил олгогчид шаардлагатай үр чадвараа стандартчилагдсан хэлбэрээр тодорхойлдоггүй. Үүний үр дүнд хөдөлмөрийн зах зээлд үр чадварын эрэлт, нийлүүлэлтийн нийцэл (matching efficiency) буурч, боломжит бүтээмжийн алдагдал үүсэж байна.

Энэ нөхцөлд хэрэгжиж буй зарим санаачилгууд системийн түвшний шийдлийн эхлэл болж байгаа юм. “Grow with Google Mongolia” хөтөлбөр нь богино хугацаанд зах зээлд шаардлагатай үр чадварыг олгох, салбарын экспертүүдтэй хамтран практикт суурилсан сургалтын загвар Монголд ажиллах боломжтойг харуулсан бодит жишээ болж байна. Хөтөлбөрт хамрагдсан суралцагчдын дунд ажлын байр ахих, шинэ салбарт шилжих, олон улсын зах зээлд ажиллах боломж нээгдэх зэрэг үр дүн ажиглагдаж байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд суурилсан, богино хугацааны сургалтын үр өгөөжийг харуулж байна. Илүү чухал нь энэ төрлийн хөтөлбөрүүд үр чадварын хөгжлийг дан ганц боловсролын салбарын асуудал биш, эдийн засгийн бодлогын хэрэгсэл болгон ашиглах боломжийг нээж байгаа юм.

01

**Skills Intelligence
тогтолцоо**

Онлайн платформуудын өгөгдлийг нэгтгэн бодит цагийн үр чадварын мэдээллийн систем бий болгох

02

**Санхүүгийн
механизм**

Сургалтын ваучер, орлогоос хамаарсан төлбөр, ажил олгогчийн татварын урамшуулал нэвтрүүлэх

03

**Модульчлагдсан
боловсрол**

Богино хугацааны мэргэшүүлэх хөтөлбөрийг үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх тогтолцоо

04

**Хамтын
ажиллагаа**

Ажил олгогч, албан болон албан бус боловсролын салбар хамтарсан хөтөлбөр, дадлагажих болон ажлын байран дээрх сургалтыг өргөжүүлэх

05

**Орон нутгийн
хүртээмж**

Дижитал дэд бүтэц болон онлайн сургалтыг нийгмийн тэгш байдлын хэрэгсэл болгон бодлогын төвд авч үзэх

06

**Эрэлтэд
тулгуурласан загвар**

"Grow with Google Mongolia" зэрэг кэйс дээр тулгуурлан практикт суурилсан богино хугацааны мэргэшүүлэх сургалтыг эрчимжүүлэх

Эдгээрээс үзэхэд, цаашид бодлогын түвшинд анхаарах шаардлагатай хэд хэдэн чиглэл тодорхой байна.

Нэгдүгээрт, хөдөлмөрийн зах зээлийн бодит цагийн мэдээлэлд суурилсан үр чадварын төлөвлөлтийн системийг бий болгох шаардлагатай юм. Онлайн платформуудын өгөгдлийг нэгтгэн дүн шинжилгээ хийдэг үр чадварын мэдээллийн нэгдсэн тогтолцоо (skills intelligence) нь бодлогын шийдвэрийг илүү нарийвчлалтай болгох боломжтой.

Хоёрдугаарт, үр чадварын хөрөнгө оруулалтыг дэмжих санхүүгийн механизм шаардлагатай. Үүнд сургалтын эрхийн бичиг, орлогоос хамаарсан төлбөрийн уян хатан загвар, ажил олгогчид татварын урамшуулал зэрэг багтана.

Гуравдугаарт, боловсролын системийг модульчлагдсан, уян хатан бүтэц рүү шилжүүлж, олон улсад төдийгүй ажил олгогчид тодорхой хэмжээнд хүлээн зөвшөөрсөн богино хугацааны сертификатжуулсан сургалтыг үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөх, их, дээд боловсролд дүйцүүлэн кредит тооцох зэрэг тогтолцоог бүрдүүлбэл оновчтой.

Мөн хувийн хэвшлийн оролцоог системтэйгээр нэмэгдүүлэх нь чухал бөгөөд сургалтын хөтөлбөрийг ажил олгогчидтой хамтран боловсруулах, дадлагажих, ажлын байран дээрх сургалтыг өргөжүүлэх нь үр чадварын зөрүүг бууруулах хамгийн үр дүнтэй арга хэвээр байна. Үүний зэрэгцээ орон нутгийн хүртээмжийн сайжруулалтгүй үр чадварын бодлого нийгмийн тэгш бус байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Иймд дижитал дэд бүтэц, онлайн сургалтын хүртээмжийг бодлогын төвд авч үзэх шаардлагатай юм.



Эцэст нь, Монгол Улсын эдийн засгийн дараагийн өсөлтийн шат нь байгалийн баялгаас илүүтэй хүний капиталд суурилна. Ур чадварын шилжилт нь хөдөлмөрийн зах зээлээс гадна бүтээмж, орлогын хуваарилалт, эдийн засгийн төрөлжилт, нийгмийн тогтвортой байдлыг тодорхойлох стратегийн хүчин зүйл болж байна. Иймд ур чадварыг ахиулах болон шинэ ур чадварт дахин суралцах үйл явцыг тусгай хөтөлбөрийн түвшнээс гарган, эдийн засгийн хөгжлийн бодлогын төвд байрлуулах бодит шаардлага үүсээд байна.



16-65 насны суралцагчид хамрагдлаа

Хөтөлбөрт 16 насны залуусаас 65 насны ахмад хүртэл хамрагджээ. Нас, хүйс, мэргэжил харгалзахгүй анги хамт олон, төслийн баг болж хамтарч суралцсан нь багш нараас суралцахаас гадна бие биеэсээ суралцах, цаашлаад үе хоорондын харилцаа, ойлголцлыг бэхжүүлэх боломжийг бүрдүүлэв.

Стратегийн түншлэл ба хамтын ажиллагаа


"Grow with Google Mongolia" хөтөлбөр нь төр болон хувийн хэвшил, боловсролын байгууллагууд, мэргэжлийн хамт олон болон суралцагчдын нэгдсэн оролцоонд тулгуурлан хөгжиж ирсэн билээ. Өнгөрсөн хугацаанд хөтөлбөрийн агуулга, хүртээмж, үр нөлөөг хамтдаа бүтээлцэж, Монголын залуусын үр чадварын хөгжилд хувь нэмэр оруулсан түнш байгууллагууддаа гүн талархал илэрхийлье.

2024

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



2025


ЗОХИОН БАЙГУУЛАГЧ



ХАМТРАГЧ




КОММЬЮНИТИ ХАМТРАГЧ



2026

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ



ДЭМЖИГЧ



ЕРӨНХИЙ ИВЭЭН ТЭТГЭГЧ



ДИЖИТАЛ УР ЧАДВАРЫГ ДЭМЖИГЧ



ИВЭЭН ТЭТГЭГЧ



ХАМТРАГЧ




МЕДИА ХАМТРАГЧ





282 ажлын байрны санал

Хөтөлбөрийн хүрээнд 2025 онд 61 байгууллагаас нийт 282 ажлын байрны санал ирсэн нь 2024 оныхоос даруй 4.5 дахин өссөн үзүүлэлт болов. Энэ нь ажил олгогчдын дунд дижитал ур чадвартай боловсон хүчний эрэлт нэмэгдэж байгааг харуулна.



Хөтөлбөрийн ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

"Grow with Google Mongolia" хөтөлбөр нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн 9 төрлийн дижитал ур чадварын сургалтыг хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөр нь оролцогчдыг ирээдүйн ажлын байранд шаардлагатай практик мэдлэг, ур чадвараар чадавхжуулахад чиглэдэг.

Яагаад энэ хөтөлбөрийг сонгох ёстой вэ?

Дэлхий даяар

1,600,000

"Google Career Certificate"-ыг хүлээн зөвшөөрсөн ажлын байр байна.

Дэлхий даяар

1,000,000

хүн "Google Career Certificate" хөтөлбөрт хамрагдсан.

Олон улсын зах зээл дэх
дундаж цалин

\$87,000+



Олон улс дахь төгсөгчдийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж:



Be the Next Certified Professional.



Project
management



AI for business




Data Analytics



Cybersecurity



UX Design




Digital Marketing
& E-commerce



Advanced
Data Analytics



AI essentials



IT Automation
with Python



Project Management

“Project Management” хөтөлбөр нь төслийг эхлэхээс нь дуусах хүртэл системтэйгээр төлөвлөж, багтайгаа хамт үр дүнд хүргэх чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн цогц сургалт юм.

Хөтөлбөрийн хүрээнд суралцагчид төслийн зорилго тодорхойлох, төлөвлөгөө боловсруулах, хугацаа болон нөөцөө удирдах, эрсдэлийг тооцоолох, багийн ажлыг зохион байгуулах зэрэг төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн үр чадваруудыг эзэмшдэг. Мөн цахим шилжилтэд түгээмэл ашиглаж буй “Agile Project Management” болон түүний суурь болох “Scrum, Kanban” гэх мэт тренд аргачлалуудад бодит кэйс дээр ажиллаж суралцдагаараа онцлогтой.

197 цагийн сургалтын агуулгад 143 цагийн Coursera онлайн хичээл, 30 цагийн танхимын хичээл, ажлын байран дахь сэтгэл ханамж, бүтээмжийг нэмэгдүүлэх зөөлөн үр чадвар эзэмшүүлэх сургалт болон хамт олон, хүрээллийг бэхжүүлэх хөтөлбөрүүд багтдаг. Танхимын хичээлээр суралцагчид багийн дасгал, хэлэлцүүлэг, практик кэйс дээр хамтран ажиллаж, төслийн орчинтой төстэй нөхцөлд шийдвэр гаргах туршлага хуримтлуулна.

Сургалтын явцад төслийн бичиг баримт боловсруулах, оролцогч талуудын удирдлагын төлөвлөгөө хийх, “backlog” болон “sprint” төлөвлөх, багийн хамтын ажиллагааг зохион байгуулах, төслийн үр дүнг хэмжих зэрэг ажлын байранд шууд ашиглагдах үр чадваруудыг хөгжүүлдэг.

Энэхүү хөтөлбөр нь төслийн багийн гишүүн, менежер, стартап болон бизнес хөгжүүлэгчид, шинэ үр чадвар эзэмшиж, карьераа ахиулах хүсэлтэй хүмүүст зориулсан бөгөөд технологи хөгжүүлэлт, бизнесийн удирдлага, үйлдвэрлэл, бүтээн байгуулалт зэрэг олон салбарт төслийн удирдлага хэрэгжүүлэх суурь чадамжийг бүрдүүлдэг.



Б.Хүслэн:

Төрсний дараа хөтөлбөрт хамрагдан эзэмшсэн мэдлэгээ ажил, амьдралдаа нэвтрүүлснээр албан тушаал дэвшиж, орлого 60 хувиар өссөн



Миний хувьд энэ хөтөлбөрт хамрагдсанаар зөвхөн төслийн удирдлагын талаар мэдлэгтэй болоод зогсохгүй, өдөр тутмын амьдрал болон ажил дээрээ шууд ашиглаж болох олон үр чадвар эзэмшсэн. Жишээлбэл, эрсдэл болон боломжоо урьдчилан тооцоолох, ажлаа эрэмбэлэн төлөвлөх үр чадварыг эзэмшиж,

олон зүйлийг цалгардуулахгүйгээр зохицуулж байна. Ялангуяа “Agile management”-ийн талаар илүү гүнзгий ойлголттой болсон нь миний ажиллах арга барилд нөлөөлж, удирдлагаа тогтмол мэдээллээр хангаж, ойр ойрхон шинэчлэл хийн, нягт хамтарч ажиллахын ач холбогдлыг илүү сайн ойлгосон. Мөн охиноо төрүүлээд 2 сартай байхаас нь ажлаа зайнаас бага цагаар үргэлжлүүлэн хийхэд тусалсан нь амьдралын хэмнэлээ алдахгүй байж, төрсний дараах үеийг илүү тогтвортой давахад нөлөөлсөн. Хөтөлбөрийн бас нэг давуу тал нь онол, практик хослуулж, бодит жишээн дээр ажиллуулдаг байсан нь сурсан зүйлээ богино хугацаанд шууд хэрэгжүүлэх боломж олгосон. Мөн ойлгоход төвөгтэй зүйлсээ чиглүүлэгч багшаасаа монгол хэлээрээ асууж, тодруулга авах боломжтой байсан нь суралцахад илүү дөхөм болгосон.

Хөтөлбөрийн дараа миний карьер ч өөрчлөгдсөн. Өмнө нь баталгаажуулалтын менежерээр ажиллаж байсан бол одоо ерөнхий менежер болж албан тушаал дэвшсэн. Үүнийхээ хажуугаар төсөл суурьтай байгууллагад чанарын менежерээр ажиллаж байна.

Мөн хөтөлбөрөөс өмнөх орлоготой харьцуулахад миний орлого 60 хувиар өссөн. Гэхдээ миний хувьд хамгийн үнэ цэнтэй өөрчлөлт нь ганц карьерын өсөлт биш. Өмнө нь ганц бие байхдаа нэг ажил л хийдэг байсан бол одоо хоёр ажлаа зэрэг амжуулахын хажуугаар гэр бүл, хүүхэдтэйгээ чанартай цаг хугацааг өнгөрүүлж чаддаг болсон нь хамгийн том ахиц гэж боддог.



Б.Гэрэлт-Оч:

Орчин цагийн мал аж ахуй, байгаль орчны нөхөн сэргээлтэд хэрэгтэй төслийн удирдлагын арга барилыг “Grow with Google Mongolia” хөтөлбөрөөс суралцсан



Би Дорнод аймагт мал маллаж, сүүний үйлдвэрээ хөгжүүлэн ажилладаг. Хөдөө орон нутагт амьдардаг хүний хувьд технологи, төслийн удирдлага гэхээр надаас нэлээд хол зүйл мэт санагддаг байсан үе бий.

Заримдаа “Хэрвээ би гадаадад сурч, ажиллаж байсан бол Google-ийн мундаг мэргэжилтнүүдтэй мөр зэрэгцэн ажиллаж, суралцаад, тэндээсээ олсон мэдлэг туршлагаа эх орондоо авчирч ашиглах байсан болов уу” гэж боддог байлаа.

Гэхдээ энэ бодол мөрөөдөл хэвээр үлдэх ёсгүй юм байна гэдгийг ойлгож, орчин цагийн мал аж ахуй, байгаль орчны нөхөн сэргээлтэд хэрэгтэй төслийн удирдлагын арга барил суралцахаар “Grow with Google Mongolia” хөтөлбөрт элссэн.

Суралцах хугацаандаа Бямба гараг бүр Дорнодоос Улаанбаатарт ирж, анги хамт олонтойгоо танхимаар хичээллэнэ. Харин бусад өдрүүдэд зайнаас сургалтаа үзнэ. Ядарсан үе байсан ч өөрийгөө хөгжүүлэх хүсэл маань илүү хүчтэй байсан.

Миний цаашдын нэг том зорилго бол мал хариулах робот зохион бүтээх. Монгол ахуйгаа технологийн дэвшилтэй хослуулж, илүү ухаалаг, үр ашигтай шийдэл бий болгохыг хүсдэг. Би энэ хөтөлбөрт хамрагдаад заавал гадаадад суралцахгүйгээр сурахыг хүсдэг зүйлсээ мэдэж, мөрөөдөл маань надаас тийм ч хол биш байсныг ойлгосон.



Б.Мөнхбилгүүн:

Хөтөлбөрөөс сурсан ур чадвар, итгэл, урам зоригоороо албан тушаал хавсран хашиж нэмэлт орлогын эх үүсвэртэй болсон



Анх өөрийн карьерыг дараагийн түвшинд гаргаж, ур чадвараа нэмэгдүүлье гэж шийдээд “Grow with Google Mongolia” хөтөлбөрт хамрагдсан. Тэр ч утгаараа хөтөлбөрт төслийн менежментийн чиглэлээр суралцаж төсөл хэрхэн удирдах талаар маш нарийн системтэй суралцаж хангалттай мэдлэг, ойлголттой болж чадсан.

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд сэтгэл зүрхээ зориулан тууштай ажилласан ажлаасаа гарч, эцсийг нь үзэж чадаагүйдээ сэтгэл гонсгор, нэг л хоосон мэдрэмжтэй явах үедээ энэхүү хөтөлбөрт хамрагдаж, тасралтгүй суралцан өөрийгөө хөгжүүлж чадсаны үр дүнд маш том урам зориг, итгэлийг олж авч чадсан.

Өөрийгөө төслийн менежментийн талаар хангалттай мэдлэгтэй гэж боддог байсан ч энэхүү хөтөлбөрт суралцах явцдаа төсөл эхлэхээс хаагдах хүртэлх бүх үе шатууд маш чухал болохыг ойлгож авсан. Мөн санхүүгийн мэргэжил дээрээ төслийн удирдлагын ур чадварыг нэмэгдүүлснээр өөрт минь аливаа төслийг үйл ажиллагаа болон санхүүг талаас нь тэнцвэртэй харж, төлөвлөж, мэдэрч ажиллах давуу тал ажиглагдаж байна.

Улмаар 2025 оны аравдугаар сараас эхлэн уул уурхайн компанид Төслийн менежер болон Санхүүгийн менежерийн албан тушаалд зэрэг ажиллаж эхэлсэн бөгөөд сарын цалин маань ч 75 хувиар нэмэгдсэн байна. Үндсэн ажлынхаа хажуугаар шинээр эхэлж буй төслүүдэд зөвлөх үйлчилгээ үзүүлдэг өөрийн бизнесийг эхлүүлээд амжилттай үйл ажиллагаа явуулж байгаа. Энэхүү бизнесээ хөгжүүлэхийн тулд хөтөлбөрийн турш сурсан хичээлүүдээ эргэн харж, төслийн менежментийн ойлголтуудаа сэргээх байдлаар ажиллаж байна даа.



Б.Баярчимэг:

Тус хөтөлбөр хувь хүний хөгжилд минь эргэлтийн цэг авчирч, бизнесийн цар хүрээгээ 60 хувиар тэлэхэд тусалсан



“Grow with Google Mongolia” хөтөлбөр миний хувьд мэргэжлийн болон хувь хүний хөгжлийн жинхэнэ эргэлтийн цэг болсон юм. Би олон жилийн турш хүнсний чанар, аюулгүй байдал, зочлох үйлчилгээний салбарт ажиллаж, өөрийн бизнесийг 2020 онд эхлүүлсэн ч КОВИДын дараа үйл ажиллагаа маань тодорхой хэмжээнд зогсонги байдалд орсон байлаа.

Туршлага, мэдлэг байсан ч ажлаа илүү системтэйгээр төлөвлөх, үр дүнг хэмжих, дүгнэх тал дээр дутмаг байгаагаа ойлгож байсан ч яг хаанаас эхлэхээ мэдэхгүй явсан үе.

Харин төслийн менежментийн сургалтад хамрагдсанаар өмнө нь хийж байсан ажлуудаа эргэн харж, анзаараагүй алдаа, сул талаа тодорхойлж, өөрийгөө шинэ өнцгөөс олж харж чадсан. Энэ нь миний хувьд хамгийн том өөрчлөлт байлаа. Зорилгоо тодорхойлох, цаг барих, багаар ажиллах чадварт суралцаж, эрсдэлийг тооцоолох зэрэг ойлголтуудыг бодит амьдрал дээр хэрэгжүүлж эхэлснээр аливааг илүү системтэй, цэгцтэйгээр харж сурсан. Үүний үр дүнд би илүү олон кампанит ажил, арга хэмжээ, шинэ төслүүдийг санаачлан хэрэгжүүлж, бизнесийнхээ цар хүрээг 60 хувиар тэлж чадсан.

Мөн энэ хөтөлбөр мэдлэг олгохоос илүүтэйгээр ижил зорилготой, тасралтгүй суралцах хүсэлтэй хүмүүсийг нэгтгэсэн орчин байлаа. Тиймээс хүн бүр энэ хөтөлбөрт хамрагдах боломжтой. Арга хэмжээ, уулзалтуудад идэвхтэй оролцсоноор танилын хүрээгээ ч тэлж, шинэ санаа, урам зориг авч чадсан. Өмнө нь “төсөл” гэдэг зүйл надаас хол мэт санагддаг байсан бол одоо харин өдөр тутмын ажилтай минь хамгийн ойр, төвөггүй хийж чадах зүйл болон хувирчээ. Энэ хөтөлбөр надад бизнесээ тэлэх боломжийг олгож, илүү өргөн хүрээнд сэтгэж, системтэй ажиллах чадварт сургасан юм.



О.Сэлэнгэ:

Хүрээлэл маань ихэвчсэн салбар дотроо байсан. Харин хөтөлбөрөөр өөр өөр мэргэжлийн хүмүүстэй ярилцаж, харах өнцөг маань тэлсэн



“Grow with Google Mongolia” хөтөлбөрт өнгөрсөн жил төслийн удирдлагын чиглэлээр суралцсан нь миний хувьд чухал алхам байсан. Анх бүртгүүлэхдээ төслийн удирдлага уу, дижитал маркетинг уу гэж нэлээн эргэлзэж байгаад, ажил мэргэжилтэйгээ илүү уялдах сонголтыг хийсэн юм.

Гэхдээ суралцах явцдаа видео контентын уралдаанд оролцож, дахин нэг курс үзэх эрх авч, хүсэж байсан дижитал маркетингийнхаа хичээлийг давхар судалж чадсан. Тэр үед хүсэл зорилгынхоо төлөө зоригтой алхам хийвэл боломж үргэлж гардаг гэдгийг бодитоор ойлгосон. Би эм зүйч мэргэжилтэй л дээ. Хөтөлбөрийн үнэ цэн миний хувьд ганц хичээл байгаагүй. Зөөлөн ур чадварын сургалт, карьер хөгжлийн эвентүүд надад өөрийгөө эргэн харах, зорилгоо тодорхойлох арга барил өгсөн.

Аль болох бүх арга хэмжээнд оролцохыг хичээсэн маань надад маш их өгөөжтэй байсан шүү. “Quiz Night”-д багаараа түрүүлж, спортын өдөрлөгөөс анхны медалиа авсан маань сайхан дурсамж үлдээсэн. Мөн энэ хөтөлбөрөөр дамжуулан хүрээллээ тэлж чадсан нь хамгийн том өөрчлөлт гэж боддог.

Эм зүйч гэдэг утгаараа хүрээлэл маань ихэвчлэн салбар дотроо байдаг. Харин энд инженер, IT, санхүү, маркетинг гээд олон төрлийн салбарын хүмүүс нэг дор цугласан болохоор өөр өөр мэргэжлийн хүмүүстэй ярилцаж, харах өнцөг минь тэлсэн нь надад их чухал байсан. Ер нь сониуч байж, чадахгүй юм шиг санагдсан ч хүссэн зүйлээ туршаад үзэх хэрэгтэй юм билээ. Цуглуулсан дурсамж, тэлж өргөжүүлсэн хүрээлэл, өөрийгөө нээсэн мөчүүд л хамгийн үнэтэй байдаг гэдгийг ойлгосон.



Б.Батчулуун:

Зөөлөн ур чадварыг
өөрөө ч мэдээгүй байхад
ухамсарт минь суулгаж
өгсөн нь хамгийн үнэ
цэнтэй байлаа



Стартап орчинд ажилладаг хүний хувьд “Grow with Google Mongolia” хөтөлбөрийн Төслийн удирдлагын хөтөлбөрт хамрагдаад, өөрт хамгийн их дутагдаж байсан зүйлээ олж харсан. Гарааны бизнес эрхлэгчид ихэвчлэн асуудлыг хараад шууд шийдэхийг хүсдэг, хурдтай, эрчтэй хүмүүс байдаг.

Гэвч системтэй, шат дараатай төлөвлөх чадвар заримдаа дутмаг байдгийг ойлгосон. Энэ хөтөлбөрөөр дамжуулан “зураглал, төлөвлөгөө” гэдэг ойлголтыг анх удаа бодитоор ухаарсан юм. Төсөл гэдэг байгууллага удирдахад л хэрэгтэй байдаг зүйл биш, харин амьдралын аливаа шийдвэр, зохион байгуулалт бүрд хэрэглэж болдог сэтгэлгээ юм байна гэдгийг тэнд ухаарсан юм. Танхимын хичээлүүд онол, практикийг маш ойлгомжтой холбож өгсөн санагдсан. Дээрээс нь IT инженер, төрийн албан хаагч, багш, оюутан гээд олон салбарын хүмүүстэй хамт суралцсан нь хүрээллийг минь тэлж, өдөр тутмын давтагдсан орчноос гарч, шинэ өнцгөөс харах боломж олгосон. Миний хувьд хөтөлбөрөөс олж авсан хамгийн чухал үнэ цэн сурсан зүйлээ амьдралтайгаа холбох цэгээ олсон явдал. Мэдлэгийг хэрэгжүүлэхгүй бол хайран шүү дээ. Харин хэрэгжүүлж чадвал тэр нь бодит өөрчлөлт болох учиртай. Нөгөө талаас, спорт өдөрлөг, өглөөний гүйлт, ууланд гарах, уралдаан тэмцээн гээд хичээлээс гадна оролцооны орчин ихтэй. Зөөлөн ур чадварыг “сур, сур” гэж шахахгүйгээр төслөөр, тоглоомоор, харилцаагаар дамжуулж, өөрөө ч мэдээгүй байхад ухамсарт минь суулгаж өгсөн нь маш их таалагдсан.



Г.Энхмөрөн:

Карьераа түр
завсарласан ч
мөрөөдлөө орхиогүй



Би аялал жуулчлалын чиглэлээр төгсөөд, оффис менежер, тийз захиалгын ажилтан, хүний нөөц зэрэг олон чиглэлээр ажилласан л даа. Харин хүүхдүүдийнхээ хүмүүжил, боловсролд анхаарал хандуулахын тулд карьераа хэсэг хугацаанд хойш тавьсан юм. Хүүхдүүд маань өсөж, өөрийгөө дахин хөгжүүлэх цаг ирэхэд “Grow with Google Mongolia” хөтөлбөрийн төслийн удирдлагын ангид элссэн нь миний хувьд шинэ эхлэл болсон юм.

Энэ хөтөлбөр надад зөвхөн төслийн удирдлагын мэдлэг олгоогүй. Харин өөртөө итгэх итгэл, эрч хүчээ дахин олоход тусалсан. Хичээлээ үзэхийн зэрэгцээ марафонд бэлтгэж, хувийн зохион байгуулалт, тэсвэр хатуужлаа шинэ түвшинд хүргэсэн. Мөн спортын өдөрлөг, бусад үйл ажиллагаануудаар дамжуулан ангийнхантайгаа нэг гэр бүл шиг дотно болж, хамтдаа олон сайхан дурсамж бүтээсэн нь хамгийн үнэ цэнтэй мөчүүдийн нэг байсан.

Харин хамгийн том өөрчлөлт нь олон жилийн турш дотроо бодож явсан бизнес санаагаа бодит төсөл болгохоор зориглосон явдал. Гүйлтийн спорт болон хүртээмжтэй орчны асуудлыг нэгтгэсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон гүйгчдэд зориулсан 100% хүртээмжтэй кофе шопын төслөө боловсруулж, баг бүрдүүлэн төслийн тэмцээнд оролцохоор бэлтгэж байгаа. Миний хувьд “Grow with Google Mongolia” гэр бүлдээ цаг гаргахын хажуугаар өөрийгөө хөгжүүлж, мөрөөдлөө бодит ажил болгох итгэл өгсөн үнэ цэнтэй боломж байсан.



Data Analytics

“Data Analytics” хөтөлбөр нь өгөгдлийг боловсруулах, түүнээс утга, зүй тогтол гаргаж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргах боломжийг бий болгох, системтэйгээр задлан боловсруулах, аналитик сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн цогц сургалт юм.

Хөтөлбөрийн хүрээнд суралцагчид өгөгдлийн сан үүсгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийхээс эхлээд үр дүнг бүтээлч хэлбэрээр тайлагнах хүртэлх бүтэн цикл ажиллах ур чадварыг эзэмшдэг. “SQL, Python, Tableau, R” зэрэг олон улсын түвшинд өргөн хэрэглэгддэг хэрэгслүүдийг ашиглан бодит өгөгдөлд суурилсан кэйсүүд дээр ажиллаж, практик ур чадвар эзэмшдэг.

Мөн статистикийн шинжилгээ, таамаглал хийх, өгөгдлийн шинжилгээ, машин сургалтын суурь ойлголтуудтай танилцаж, их хэмжээний өгөгдлөөс үнэ цэнтэй мэдээлэл илрүүлэх, ирээдүйн өөрчлөлтийг таамаглах, өгөгдөлд суурилан шийдвэр гаргах арга барилд суралцдаг.

Сургалтын агуулгад 200+ цагийн Coursera онлайн хичээл, 30 цагийн танхимын хичээл, нэмэлт зөөлөн ур чадвар болон өсөж дэвжих хамт олон, хүрээллийг бэхжүүлэх хөтөлбөрүүд багтдаг бөгөөд танхимын сургалтын үеэр суралцагчид бодит кэйс дээр хамтран ажиллаж, өгөгдлийг тайлбарлах, ойлгомжтой байдлаар танилцуулах, өгөгдлийн дүн шинжилгээнд суурилсан бүтээгдэхүүний болон бизнесийн шийдэл боловсруулах туршлага хуримтлуулна.

Энэхүү хөтөлбөр нь өгөгдлийн шинжээч, бизнесийн шинжээч чиглэлээр ажиллаж буй мэргэжилтнүүдээс гадна мэдээллийн технологи, маркетинг, санхүү, судалгаа зэрэг өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт шаарддаг салбарт ур чадвараа ахиулах хүсэлтэй хүмүүст зориулсан юм.



Р.Хатансайхан:

“Grow with Google Challenge”-д ялагч болсон төслөөрөө эрдэм шинжилгээний хуралд 3-р байр эзэлсэн



Энэ хөтөлбөрт хамрагдахаас өмнө би өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх хэрэгтэй гэдгээ мэддэг байсан ч хаанаас, яаж эхлэхээ сайн мэддэггүй байсан. Хөтөлбөрийн эхний үед надад мэдэхгүй, чадахгүй зүйл их гарч ирсэн. Заримдаа хичээлээ гүйцэхгүй юм шиг санагдах үе ч байлаа. Гэхдээ долоо хоног өнгөрөх тусам хичээлүүд илүү ойлгомжтой болж, мэдлэг, ур чадвар маань сайжирч, өөрчлөгдөж байгааг анзаарч эхэлсэн.

Миний энэ өөрчлөлтөд хамгийн их нөлөөлсөн зүйл нь хамт олон байсан гэж боддог. Уг хөтөлбөрт салбар салбарын манлайлагчид, өөрөөс минь илүү туршлагатай хүмүүс хамрагддаг учраас шинэ зүйл сурах боломж маш их гэдгийг мэдсэн. Мэдэхгүй зүйл гарвал цаг алдалгүй асууж, туршлагатай хүмүүсээс шууд суралцах нь надад том давуу тал шиг санагдсан. Мөн танхимын болон салбартаа тэргүүлэх мэргэжилтнүүдтэй уулзаж, тухайн салбарын бодит нөхцөл байдал, чиг хандлагыг илүү өргөн өнцгөөс харсан.

Мэргэжлийн хувьд ч сурсан зүйлсээ бодитоор ашиглаж, судалгаандаа хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд “Grow with Google Challenge”-д сонгууль болон сонгогчдын тоотой холбоотой судалгаагаар оролцож, ялагч болсон. Үүний дараа тухайн сэдвээрээ үргэлжлүүлэн судалгаа хийж хэвлүүлэн Сонгуулийн ерөнхий хорооноос зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд оролцож 3-р байр эзэлсэн.

Одоогоор Хууль зүйн үндэсний хүрээлэнд эрдэм шинжилгээний ахлах ажилтнаар ажиллаж байна. Мөн найзуудтайгаа хамтран төрийн бус байгууллага байгуулж, суралцсан судалгааны ур чадвараа ашиглан шинэ ажлууд эхлүүлээд явж байна. Энэ хугацаанд миний карьер ч өөрчлөгдсөн. Шинэ ажилд орж, албан тушаал ахиж, орлого маань 2024 оноос хойш 50 хувиар өссөн.



Э.Золзаяа:

Хүний нөөцийн салбарт өгөгдөл шинжилгээ хийж эхэлснээр шийдвэр гаргалт, стратегийн түвшинд ажиллах боломж бүрдсэн



Анх 2024 онд “Grow with Google Mongolia” хөтөлбөрт хамрагдаж байлаа. Би хүний нөөцийн салбарт ажилладаг. Манай салбарт өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт маш чухал болж эхэлсэн. Тиймээс ч энэхүү хөтөлбөр миний карьерыг дараагийн түвшинд гаргах ганц боломж гэж бодсон юм.

Тэр үед тоон мэдээллийг гүнзгий задлан шинжилж, цэвэрлэж, боловсруулж ашиглах тал дээр өөртөө хангалттай итгэлгүй байлаа.

Харин энэхүү хөтөлбөрийн явцад өгөгдөл шинжилгээний суурь ойлголтуудыг бодитоор эзэмшиж, өдөр тутамдаа шууд хэрэгжүүлж сурснаар хүний нөөцийн чиглэлд илүү стратегийн түвшинд ажиллаж сурсан даа.

Өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, дүн шинжилгээ хийх чадвар нэмэгдсэнээр ажлын үр дүн мэдэгдэхүйц сайжирч, өөрийгөө илүү үнэ цэнтэй мэргэжилтэн болгож чадсан. Үр дүнд нь 100 орчим ажилтантай байгууллагаас 1,200 хүний нөөцтэй томоохон компанид шилжин ажиллаж, цалингийн хувьд 20 хувийн өсөлт хүртсэн байна. Мөн ажлынхаа хажуугаар хүний нөөцийн сонгон шалгаруулалт, аудитын чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлж эхэлсэн нь өөрийн үр чадварыг илүү өргөн хүрээнд ашиглах боломжийг ч нээсэн.

Өгөгдөл шинжилгээг илүү ойлгож эхэлснээр хиймэл оюун болон технологийг илүү ойлгож, нарийн ашиглаж сурчээ. Мөн хамт суралцаж буй хүмүүсийн туршлага, түүхээс урам авч, хамтдаа өсөж хөгжих орчин ямар үнэ цэнтэй болохыг ойлгосон. Цаашид ч тасралтгүй суралцаж, өгөгдөл дүн шинжилгээ хийх үр чадвараа гүнзгийрүүлсээр байх болно.



89% нь “Google Career Certificate” эзэмшлээ

Олон улсад цахимаар бие даан “Google Career Certificate” хөтөлбөрт хамрагдсан оролцогчдын зөвхөн 5-14% нь бүрэн хамгаалсан байдаг бол “Grow with Google Mongolia” хөтөлбөрийн оролцогчдын 89% хувь нь сертификатаа бүрэн хамгаалж чаджээ.



Cybersecurity

“Cybersecurity” хөтөлбөр нь байгууллагын мэдээлэл, систем, цахим дэд бүтцийг кибер халдлагаас хамгаалах суурь мэдлэгийг бодит практиктай хослуулан эзэмшүүлэх мэргэжлийн сургалт юм.

Хөтөлбөрийн хүрээнд суралцагчид кибер халдлагын үндсэн төрлүүд, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл, хамгаалалтын суурь аргачлалуудтай танилцаж, халдлагыг илрүүлэх, хариу арга хэмжээ авах, системийн эмзэг байдлыг үнэлэх суурь чадвар эзэмшинэ. Мөн “Security Information and Event Management” (SIEM), “Intrusion Detection Systems” (IDS) зэрэг орчин үеийн кибер аюулгүй байдлын хэрэгслүүдтэй ажиллаж сурдаг.

Хөтөлбөрийн хүрээнд суралцагчид 170 гаруй цагийн Coursera онлайн хичээл болон танхимын практик хичээлд хамрагдаж, мэдээллийн аюулгүй байдлын бодит жишээ, тохиолдлууд дээр ажилладаг. Ингэснээр кибер халдлагын шинж тэмдгийг таних, эрсдэлийг үнэлэх, байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах арга барилд суралцдаг.

Сургалтын явцад Linux, Python, SQL зэрэг хэрэгслүүдийг ашиглан дижитал хөрөнгийг хамгаалах, системийн лог анализ хийх, “incident response” хэрэгжүүлэх, автоматжуулалт ашиглан аюулгүй байдлын процессыг сайжруулах суурь ур чадваруудад суралцана.



Д.Цэнгэл:

Хөрвөх чадвартай
мэргэжилтэн болж,
ажиллах цар хүрээ
мэдэгдэхүйц тэлж, сарын
орлого маань 20 хувиар
нэмэгдсэн



Миний хувьд технологийн салбарт хөл тавьж, мэдлэгээ тэлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг сонгосон. Хөтөлбөрийн үр дүнд миний ажил болон мэргэжлийн үнэ цэн бүрэн шинэ шатанд гарлаа.

Өмнө нь англи хэлний ерөнхий орчуулга хийдэг байсан бол одоо мэдээллийн технологи, тэр дундаа кибер аюулгүй байдлын чиглэлээр мэргэшсэн орчуулгуудыг хийж байна.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас хэрэгжүүлж буй олон улсын төслүүд, кибер аюулгүй байдлын аудитын шалгалт болон баримт бичгийн орчуулга дээр тогтмол ажиллах болсон. Саяхан Засгийн газрын ордонд зохион байгуулагдсан хиймэл оюун, өгөгдөл шинжилгээний талаар томоохон арга хэмжээний бүтэн өдрийн синхрон орчуулгыг бие даан гүйцэтгэлээ. CV дээр минь нэмэгдсэн “Google Career Certificate in Cybersecurity” нь мэргэжлийн хүрээнд өндөр итгэлцэл төрүүлж, салбарын төслүүдэд сонгогдон ажиллахад гол нөлөө үзүүлж байна.

Энэхүү хөтөлбөрт хамрагдсанаас хойш миний ажиллах цар хүрээ мэдэгдэхүйц тэлж, СУИС-ийн Кино, телевиз, медиа урлагийн сургуулийн захирал болж дэвшлээ. Мөн сарын орлого маань 20 хувиар нэмэгдсэн. Технологийн салбарын мэдлэгтэй болсноор ажлынхаа хажуугаар нарийн мэргэжлийн орчуулга хийж, нэмэлт орлого олох боломжууд нээгдлээ. Хөтөлбөрөөс олж авсан мэдлэг маань намайг орчин үеийн хөдөлмөрийн зах зээлд хөрвөх чадвартай, өрсөлдөхүйц мэргэжилтэн болоход үнэлж баршгүй хувь нэмэр орууллаа.



Г.Болортунгалаг:

Увс аймгаас 24 цаг автобусаар явж хичээлдээ оролцдог байлаа. Сургалтаас авсан мэдлэгтээ үндэслэн аймгийн хэмжээнд мөрдөх “Кибер аюулгүй байдлын журам”-ыг боловсруулж байна



Би 2025 онд “Grow with Google Mongolia” хөтөлбөрт кибер аюулгүй байдлын чиглэлээр хамрагдсан. Анх тус хөтөлбөр 2024 онд зарлагдахад надаас алс, хүрэхэд бэрх зүйл мэт санагдаж байлаа. Харин 2025 онд насны хязгаар нь 35 хүртэл гэж зарласныг хараад, зориглон хүсэлтээ илгээсэн.

Тэнцсэн урилга ирэхэд итгэж ядаж байлаа. Учир нь хүсэлт илгээснээс хойш ердөө 7 хоногийн дараа 36 нас хүрэх байсан юм. Ажлын ачаалал их, орон нутагт амьдардаг ч Увс аймгаас 24 цаг автобусаар явж хичээл, арга хэмжээндээ оролцдог байсан. Хичээлээ дуусгаад дахиад 24 цаг явж гэртээ ирнэ. Амаргүй байсан ч зорилго маань тодорхой байсан. Мөн англи хэлний бэрхшээл байсан ч орчуулж, ойлгож, тууштай суралцсан.

Миний хувьд энэ хөтөлбөрийн хамгийн том үнэ цэн нь ажлаа илүү системтэй ойлгох боломж байсан юм. Аймаг дахь цахим шилжилтийн асуудлыг хариуцан ажилладаг хүний хувьд кибер аюулгүй байдлын цэгцтэй ойлголт зайлшгүй хэрэгтэй байсан. Сургалтаас авсан мэдлэг дээрээ үндэслэн одоо аймгийн төрийн байгууллагуудад мөрдөх “Кибер аюулгүй байдлын журам”-ыг боловсруулж, бодит өөрчлөлт хийх шатандаа явж байна. Энэ бол миний хувьд сургалтаас шууд гарсан үр дүн.

Энэ хөтөлбөр надад мэдлэг эзэмших, өөрийгөө сорих, шинэ орчинд нүд нээх боломж өгсөн. Хамт суралцсан хүмүүс, эвентүүд, шинэ орчин надад маш их нөлөөлсөн.



58% нь эмэгтэй суралцагчид байв

Нийт төгсөгчдийн 58% нь эмэгтэйчүүд байлаа. Үүн дотроос эмэгтэй бизнес эрхлэгчид, дөнгөж амаржсан, гэртээ хүүхдээ харж байгаа эхчүүд уян хатан ажлын байр, нэмэлт орлогын сувгаа нээж чадсан юм.



Digital Marketing & E-Commerce

“Digital Marketing & E-Commerce” хөтөлбөр нь дижитал орчинд хэрэглэгч татах, борлуулалт нэмэгдүүлэх, брэндийн үнэ цэнийг өсгөх орчин үеийн маркетингийн ур чадварыг практик байдлаар эзэмшүүлэх цогц сургалт юм.

Хөтөлбөрийн хүрээнд суралцагчид сошиал медиа стратеги боловсруулах, төлбөрт сурталчилгаа (Meta, Google) ажиллуулах, хайлтын системийн оновчлол (SEO) болон хайлтын системийн маркетинг (SEM) ашиглан хэрэглэгчийн урсгалыг нэмэгдүүлэх, маркетингийн үр дүнг хэмжиж шинжлэх зэрэг дижитал маркетингийн үндсэн аргачлалуудыг сурна. Мөн “Google Ads, Google Analytics, Shopify, Mailchimp” зэрэг платформууд дээр ажиллаж, өгөгдөлд суурилсан маркетингийн шийдвэр гаргах чадвар эзэмшинэ.

Суралцагчид 180 гаруй цагийн онлайн хичээлээр дижитал маркетингийн суурь мэдлэгээ хөгжүүлэхийн зэрэгцээ танхимын сургалт болон хамтдаа суралцах үйл ажиллагаануудаар дамжуулан маркетингийн бодит кэйсүүд дээр ажилладаг. Энэ хугацаанд зорилтот хэрэглэгчийг (customer persona) тодорхойлох, сошиал медиагийн контент төлөвлөгөө боловсруулах, маркетингийн кампанит ажлын стратеги боловсруулах зэрэг ур чадваруудыг практик байдлаар эзэмшинэ.



Б.Амартөгс:

Шинэ мэдлэгээс гадна
шинэ хүрээлэл, шинэ
өнцөг, шинэ итгэл олж
авсан



Би хүний нөөцийн салбарт, тэр дундаа сонгон шалгаруулалтын чиглэлээр ажиллаж байхдаа “Grow with Google Mongolia” хөтөлбөрийн талаар анх сонссон юм. Ажлын орчин маань улам бүр дижитал болж, өгөгдөл, сошиал сувгууд, онлайн харилцаа чухал болж буйг мэдэрч байсан учраас өөрийн ур чадварыг шинэ шатанд гаргахыг хүссэн.

Тиймээс ажлын байран дээрээ илүү бүтээлч, үр дүнтэй ажиллах зорилго тавиад, “Digital Marketing & E-Commerce” чиглэлээр суралцсан. Сургалтын туршид дижитал маркетингийн суурь ойлголтуудыг системтэйгээр эзэмшсэнээс гадна долоо хоног бүр салбарын манлайлагчид бодит туршлагаа хуваалцаж, сурсан мэдлэгийг практикт хэрхэн хэрэгжүүлэхийг зааж өгсөн нь их үнэ цэнтэй санагдсан.

Би хөтөлбөрөөс авсан мэдлэгээ зөвхөн борлуулалт, маркетингийн чиглэлд гэлтгүй, өөрийн хүний нөөцийн ажилд шууд ашиглаж эхэлсэн байгаа. Ажил олгогчийн брэндинг, сошиал сувгийн стратеги, ажлын зар сурталчилгааны контент боловсруулах зэрэгт дижитал маркетингийн сэтгэлгээ бодитоор хэрэг болсон шүү. Ингэснээр хүний нөөцийн ажлыг илүү стратеги, өгөгдөлд суурилсан байдлаар харах боломжтой болсон юм.

Миний хувьд тус хөтөлбөрийн онцлог нь эрэлттэй ур чадвар заахаас гадна онол, практикийг хослуулсан багш нар, олон төрлийн эвент, нетворкинг хийх орчин байлаа. Өөр өөр салбарын чадварлаг залуустай хамт суралцаж, бие биеэсээ урам авч, өөрийгөө сорьсон тэр зуны хугацаа миний хувьд шинэ үе шат руу шилжсэн туршлага болсон. Шинэ мэдлэгээс гадна шинэ хүрээлэл, шинэ өнцөг, шинэ итгэл олж авсан гэдгээрээ энэ хөтөлбөр надад онцгой санагддаг.



О.Элбэгмөрөн:

Өмнөд Суданд энхийг
сахиулж байхдаа
хөтөлбөрт оролцсон ч баг
хамт олон маань тусалж
дэмждэг байсан учраас
амжилттай төгссөн



Би 2023-2024 онд Бүгд Найрамдах Өмнөд Судан улсад явагдаж байсан НҮБ-ын мандаттай Монгол Улсын 17 дугаар батальонд алба хаасан.

Тухайн үед фэйсбүүкээс “Grow with Google Mongolia” хөтөлбөрийн мэдээллийг хараад, танилцуулгаа англи хэлээр бичиж явуулж байсан. Тэгээд нэг их удаагүй тэнцсэн тухай мэйл ирчихсэн байсан. Хөтөлбөрийн гэрээн дээр өдөрт 6-7 цаг зарцуулах шаардлагатай гэж бичсэн байсан. Түүнийг хараад “амралтынхаа хугацаанд зохицуулаад амжуулчхаж болох юм байна” гэж бодсон.

Хамгийн тод үлдсэн дурсамж гэвэл алба хааж байхдаа шумуулд хазуулахгүйн тулд торон дотор унтдаг байсан юм л даа. Тэгээд шөнө амрах цаг болоод хүмүүс унтчихсаны дараа уртасгагч, төхөөрөмжүүдээ тор руугаа оруулаад хичээлээ үздэг байсан. Заримдаа тэр орчинд хичээлээ хийхээр “ер нь хүсэл байхад хаанаас ч суралцаж болдог юм байна” гэж бодогддог байсан. Нөгөө талаараа хөтөлбөрийн хамт олон нэгэндээ тусалж дэмжин, асуух зүйл гарвал шууд хуваалцдаг байсан нь суралцахад маань эергээр нөлөөлсөн. Энэ нь надад зайнаас оролцож байсан ч хөтөлбөрийн хугацаанд хамтдаа байгаа юм шиг мэдрэмж төрүүлсэн. Энэхүү хөтөлбөр надад цаашид сурч боловсрох том хөшүүрэг болж, урам зориг өгсөн учраас би үргэлжлүүлэн их сургуульд элсэн орж, одоо суралцаж байна.

Одоо би “Bonum” компанид дижитал маркетингийн чиглэлээр ажиллаж, сурсан мэдлэгээ ажлын байран дээрээ ашиглаж байна. Миний хувьд практик дээр хийж байгаа ажлуудаа аль болох өөртөө зориулж хийдэг. Энэ нь сурсан зүйлсээ бодит амьдрал дээр ашиглахад нөлөөлсөн гэж бодож байна.



Г.Должинсүрэн:

Бизнесийнхээ хамгийн том асуудлыг шийдэхийн тулд хөтөлбөрт элссэн



Би аялал жуулчлалын салбарт 21 жил ажиллаж, өөрийн байгууллагыг удирдаж байна. Сүүлийн хэдэн жил манай компани сошиал медиа, маркетингийн чиглэлээр олон байгууллага, хувь хүнтэй хамтарч ажилласан ч борлуулалтаа бодитоор өсгөж чадахгүй байсан.

Жижиг бизнесийн хувьд борлуулалтгүй бол оршин тогтнох боломжгүй учраас энэ асуудлыг өөр хүнээр биш, өөрөө ойлгож шийдэх хэрэгтэй гэдгээ ухаарсан. Тиймээс “Grow with Google Mongolia” хөтөлбөрийн дижитал маркетингийн сургалтад хамрагдаж, маркетингийг сууриас нь сурч эхэлсэн юм.

Сургалтын явцад би сошиал медиаг пост, рийлс оруулах талбар биш, харин борлуулалттай холбогдсон цогц систем гэдгийг ойлгосон. Долоо хоног бүр сурсан зүйлээ өөрийн бизнес дээр шууд туршиж, зорилтот хэрэглэгчээ илүү тодорхойлох, бүтээлч кампанит ажил төлөвлөх, маркетингийн үйл ажиллагаагаа системтэй зохион байгуулах чадвар эзэмшсэн. Хамгийн том өөрчлөлт нь маркетингийн шийдвэрүүдээ мэдрэмжээр биш, дата болон анализ дээр үндэслэн гаргадаг болсон явдал гэж хэлж болно.

Хөтөлбөрийн үр дүнд бид маркетинг, борлуулалтын процессоо шинээр зураглаж, “ажилтан бүр борлуулагч” гэсэн соёлыг байгууллагадаа төлөвшүүлж эхэлсэн. Мөн Германд очсон залуусын дасан зохицох асуудлыг шийдэх зорилготой “Edy Way Mentorship” шинэ төслөө үндсэн үйлчилгээтэйгээ зөв уялдуулан хөгжүүлж чадсан. Миний хувьд энэ хөтөлбөр бизнесээ өөр өнцгөөс харж, дараагийн өсөлтийнх нь суурийг тавих боломж болсон гэж хэлнэ.




14.3% нь албан тушаал дэвшжээ

Суралцагчдын 14.3% нь хөтөлбөрийн төгсгөл гэхэд ажлын байран дээрээ тушаал дэвшсэн үзүүлэлттэй байна. Энэ нь хөтөлбөрөөр эзэмшсэн шинэ ур чадварууд нь карьерын өсөлтөд шууд нөлөөлснийг харуулна.



34.5% нь бизнесээ өргөжүүлэв

2025 оны судалгаагаар суралцагчдын 34.5% нь хувийн бизнесээ өргөжүүлж чаджээ. Хөтөлбөрөөр эзэмшсэн хиймэл оюун, маркетинг, дата анализ зэрэг ур чадварууд нь бизнесийн шинэ боломжуудыг нээхэд нөлөөлсөн байна.



UX Design

“UX Design” хөтөлбөр нь хэрэглэгчийн туршлагад төвлөрсөн дижитал бүтээгдэхүүн, вебсайт, аппликэйшн боловсруулах ур чадварыг эзэмшүүлэх практик сургалт юм. Хэрэглэгч бүтээгдэхүүнтэй харилцахдаа юу мэдэрч, юунд төвөгшөөж, ямар шийдэл хүсэж байгааг ойлгохоос UX дизайны процесс эхэлдэг.

Хөтөлбөрийн хүрээнд суралцагчид хэрэглэгчийн судалгаа хийх, хэрэглэгчийн дүр төрх болон хэрэглэгчийн замналын зураглал боловсруулах, ашиглахад хялбар байдлыг турших болон хэрэглэгчийн асуудлыг тодорхойлох зэрэг UX судалгааны суурь аргачлалуудыг сурна. Үүний дараа бүтцийн бүдүүвч зураг, туршилтын загвар, UI дизайны систем боловсруулах замаар санаагаа бодит бүтээгдэхүүний загвар болгон хөгжүүлэх чадвар эзэмшинэ.

Онлайн хичээлийн хэсгээр суралцагчид “Google Career Certificate”-ийн 160+ цагийн мэргэжлийн агуулгыг Coursera платформоор үздэг бол танхимын 30 цагийн хичээлээр бодит кэйс дээр ажиллаж, UX процессыг практик байдлаар туршдаг. Үүнийг нэмэлтээр зөөлөн ур чадварын сургалт болон комьюнити арга хэмжээнүүд дэмждэгээрээ онцлогтой.

Мөн Figma дээр ажиллах, зохицсон (responsive) UI загвар гаргах, хүртээмжтэй байдал болон хэрэглэгч төвтэй дизайны зарчмыг хэрэгжүүлэхээс гадна хиймэл оюуны тусламжтайгаар бүтээлч шийдэл боловсруулах аргачлалуудтай танилцдаг.

Хөтөлбөрийн төгсгөлд суралцагчид портфолиод оруулах UX төслүүд боловсруулсан байдаг нь цаашид UX дизайн, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, стартап болон дижитал бүтээгдэхүүний чиглэлээр ажиллах суурь чадвар болдог.



Г.Оргил:

Бодитоор хэрэгжүүлэх арга барилд суралцсан нь хамгийн үнэ цэнтэй санагдсан



Шинэхэн кофе болон хийл хөгжмийн хослол бүхий үйлчилгээ үзүүлдэг "For Happiness" бизнесээ эхлүүлэхдээ бид хэрэглэгчдээ сайн мэддэг гэж боддог байлаа. Манай үйлчилгээг хүмүүс Богд ууланд хийл тоглонгоо кофе зардаг газар гэж л мэддэг байсан бөгөөд маркетингийн шийдвэрүүдээ ихэвчлэн өөрсдийн төсөөлөл, мэдрэмж дээр үндэслэн гаргадаг байсан.

"Grow with Google Mongolia" хөтөлбөрт хамрагдсанаар энэ ойлголт бүрэн өөрчлөгдсөн юм. "Customer Persona, Customer Journey, SEO, Social Media Strategy, Data Analytics" зэрэг ойлголтуудыг ашиглан бид хэрэглэгчдээ илүү бодитой судалж эхэлсэн. Тухайлбал, манай гол хэрэглэгчид тогтмол ууланд алхдаг хүмүүс биш, харин найз нөхөд, хамт олонтойгоо дурсамж бүтээх зорилгоор ууланд гардаг 25–35 насны хүмүүс болохыг олж мэдсэн. Энэхүү ойлголт нь маркетингийн стратегиа шинэчлэх, брэндийн байр сууриа тодорхойлох үндэс болсон юм.

Үүний үр дүнд бид зөвхөн танигдах байдлаа нэмэгдүүлээд зогсохгүй, бизнесийн загвараа өргөжүүлж чадсан. "For Happiness" вебсайтаа хөгжүүлж, дижитал захиалгын системтэй эвентийн катеринг үйлчилгээ нэвтрүүлсэн. Мөн Богд уул дахь үйл ажиллагаанаас гадна ажлын өдрүүдэд отын төвд зөөврийн кофе үйлчилгээ үзүүлж эхэлсэн. Социал хуудасны дагагчдын тоо 400-аас 1,200 болж өсөж, бизнесийн маань орлого 30-35 хувиар нэмэгдсэн нь бидний хувьд хамгийн бодит үр дүн байлаа.

Гэхдээ миний хувьд хамгийн үнэ цэнтэй зүйл нь ганцхан бизнесийн өсөлт байгаагүй. Өөрийгөө хөгжүүлэх зорилготой олон салбарын хүмүүстэй хамт суралцаж, туршлага солилцсон нь сэтгэлгээний түвшинд том өөрчлөлт авчирсан. Өнөөдөр бидний дунд бий болсон харилцаа холбоо, харилцан дэмжлэг нь сертификатаас ч илүү үнэ цэнтэй хөрөнгө болсон гэж боддог.



А.Ану

Уламжлалт анагаах ухааныг дизайнтай хослуулж, өөрийн брэндийг бий болгосон

Би 2025 оны зун “Grow with Google Mongolia” хөтөлбөрт UX дизайны чиглэлээр хамрагдаж, 8 сард амжилттай төгссөн. Хятад уламжлалт анагаах ухааны чиглэлээр төгсөөд, одоо эмчээр ажилладаг ч дизайны салбарт сонирхолтой байсан учраас энэ хөтөлбөрт хамрагдахаар шийдсэн юм. Тухайн үед баглаа боодол, хайрцаг савны дизайнераар ажиллаж байсан ч UX дизайныг олон жил системтэй сурах хүсэлтэй явсан. Тийм болохоор энэ хөтөлбөр миний хувьд сонирхлоо мэргэжлийн түвшинд гаргах эхний бодит алхам болсон юм. Сургалтын хамгийн үнэ цэнтэй зүйл нь программ дээр ажиллахаас гадна, хэрэглэгч төвтэй сэтгэлгээ буюу дизайны сэтгэлгээг ойлгож авсан явдал. Эмчийн ажилдаа хүртэл үүнийг ашиглаж эхэлсэн.

Мэдээллийг илүү ойлгомжтой, бүтэцтэй хүргэх, өвчтөний өнцгөөс асуудлыг харах, туршлагыг нь бодолцох гээд олон зүйлд нөлөөлсөн л дөө.

Хөтөлбөрт элсэх үедээ уламжлалт анагаах ухааныг дизайнтай хослуулсан апп, веб хийнэ гэж мөрөөддөг байсан бол төгсөөд удалгүй өөрийн брэндийг үүсгэж, зөвлөгөөгөө онлайн орчинд илүү ойлгомжтой, гоё дизайнтайгаар хүргэж эхэлсэн. Зорилгоо шат дараатай тодорхойлж, бодит болгоход энэ хөтөлбөр надад их тус болсон шүү. Надад бас энэ хөтөлбөрөөс хамгийн их таалагдсан зүйл нь заавал нэг цагт шахаж суугаад байхгүй, өөрийн хурдаар суралцах боломж байсан. Google-ийн экспертүүдийн арга барил эмх цэгцтэй, шууд хэрэгжихүйц, дээрээс нь Монгол дахь экспертүүдийн бодит кэйс, эвентүүд, харилцааны ур чадварын сургалтууд нь сурах орчныг илүү амьд болгож өгсөн. Ер нь өөрт байгаа ур чадвараа тэс өөр салбартай хослуулж, шинэ зүйл бүтээхийг хүсэж байгаа хүмүүст би энэ хөтөлбөрийг санал болгоно. Суралцаад, хэрэгжүүлж чадвал энэ хөтөлбөр зөвхөн ур чадвар гэхгүй, өөрийн санааг бодит болгох итгэлийг өгдөг.



А.Ану

Уламжлалт анагаах ухааныг
дизайнтай хослуулж, өөрийн
брэндийг бий болгосон



О.Дулмаа:

Хөтөлбөрийн хүрээнд олж авсан ойлголтоо өөрийнхөө төсөлд шууд ашиглаад явж байгаадаа баяртай байгаа



Би програм хангамжийн инженер мэргэжилтэй, 5 жилийн турш “Front-End” хөгжүүлэгчээр ажилласан. Дизайнаа “Figma” дээрээс хараад, код болгодог байсан ч UX гэдэг хэрэглэгчийн сэтгэл зүй, туршлагатай холбоотой том салбар гэдгийг “Grow with Google Mongolia” хөтөлбөрийн UX Design хөтөлбөрт суралцахдаа гүнзгий ойлгосон.

Онлайн курсын хажуугаар 10 жилийн туршлагатай багшаас танхимын хичээлээрээ бодит ажил дээр хэрэг болох мэдлэг авсан нь хамгийн үнэ цэнтэй байсан гэж боддог. Дизайн спринт, хэрэглэгчийн урсгал, шийдвэр гаргалтын логикийг бодитоор сурсан л даа.

Сургалтаа төгсөөд, компанийнхаа аппликэйшний шинэчлэлт дээр UX дизайны хүрээнд зөвлөгөө өгч, санал санаачилга гарган оролцдог болсон шүү. Зүгээр код бичдэг байснаас хэрэглэгчийн туршлагыг бодож, шийдэл санал болгодог түвшинд шилжсэн маань миний карьерын хувьд бодит ахиц болсон байгаа. Хөтөлбөрийн орчин ч өөрөө онцгой.

Баг бүрдүүлж, төсөл дээр ажиллах, тэмцээн уралдаануудад оролцох зэрэг нь бодит салбарын уур амьсгалыг мэдрүүлсэн гэж хэлж болно. Миний хувьд “MNG Kids” аппликэйшний Хамтран үүсгэн байгуулагчаар ажилладаг юм. 6–12 насны хүүхдүүдэд зориулсан, англи хэл болон суурь боловсролын хичээлийг интерактив хэлбэрээр заадаг аппликэйшн. UX дизайны ойлголтоо энэ төсөлдөө шууд хэрэгжүүлж, хэрэглэгчийн урсгал, туршлагыг сайжруулахад ашиглаад явж байгаадаа баяртай байгаа.



Т.Марал:

Дизайныг зөвхөн өнгө үзэмж төдий хардаг байсан бол хөтөлбөрт хамрагдсанаар хэрэглэгч төвтэй сэтгэлгээг хөгжүүлж, карьерын үсрэлт хийсэн



Миний хувьд Skytel компанид креатив дизайнераар ажиллаж байхдаа дизайныг зөвхөн өнгө үзэмж төдийхөн гэж хардаг байв. Харин “Grow with Google Mongolia” хөтөлбөрт хамрагдсанаар хэрэглэгч төвтэй сэтгэлгээг суурь болгон эзэмшиж,

UX дизайны бодит мөн чанарыг ойлгосон маань карьерыг минь бүрэн өөрчилсөн юм.

Өмнө нь өгөгдсөн даалгаврыг шууд хийж эхэлдэг байсан бол одоо зорилгоо тодорхойлохын тулд зөв асуулт асууж, удирдлагатайгаа нэг хэлээр ойлголцож сурсан.

Ажлын арга барилын хувьд судалгаанд суурилсан тайлбар хийж, аливаа ажлыг эхлүүлэхээсээ өмнө бүтцийг нь эмх цэгцтэй төлөвлөдөг болсон. Энэхүү системтэй хандлага маань ажлын бүтээмжийг нэмэгдүүлээд зогсохгүй маркетинг дизайнер болж өсөх, улмаар орлогоо нэмэгдүүлэх боломжийг олгосон. Хөтөлбөрөөс олж авсан өсөж дэвжих сэтгэлгээ маань намайг урагшлуулсаар өнөөдөр “AND Global” компанид дижитал маркетинг менежерээр ажиллах дараагийн том алхмаа хийж байна.

Хөтөлбөрийн явцад UX дизайн ангийнхаа эрч хүчтэй, өсөж хөгжих тэмүүлэлтэй залуусаас суралцсан маань хамгийн гоё мөч байсан. Хүн бүрийн өвөрмөц өнцөг, бие биедээ өгөх санал шүүмж нь хичээл бүрийг сонирхолтой болгож, хамтдаа хөгжих таатай орчныг бүрдүүлсэн. Хамтран суралцагчдын маань ажиллах арга барил, хичээл зүтгэл надад шинэ чадвар эзэмшихээс гадна өөртөө итгэх итгэлийг бэлэглэсэн юм.



Г.Ням-Эрдэнэ:

UX дизайныг сурснаар асуудлыг олон өнцгөөс харж, хэрэглэгчийн өнцгөөс сэтгэж эхэлсэн



Би бизнесийн удирдлага мэргэжлээр төгсөж, одоогоор АПУ ХК-д хүний нөөцийн чиглэлээр ажиллаж байна. Их сургуулиа төгсөөд ажил, гэр гэсэн тогтмол хэмнэлд орсон үедээ өөрийгөө шинэ түвшинд хөгжүүлэх, шинэ хүмүүстэй танилцах, өөр салбарын мэдлэг туршлагаас суралцах хэрэгцээг илүү хүчтэй мэдэрсэн.

Тиймээс "Grow with Google Mongolia" хөтөлбөрийн UX дизайн чиглэлийг сонгож, өөрийгөө шинэ өнцгөөс сорихоор шийдсэн юм.

Хөтөлбөрийн хамгийн том өгөөж нь надад хэрэглэгч төвтэй сэтгэлгээ болон "Design Thinking" аргачлалыг ойлгуулсан явдал байсан. UX дизайн нь ганцхан дизайнеруудад зориулсан ур чадвар биш, харин аливаа асуудлыг олон талаас нь харж, илүү оновчтой шийдэл боловсруулах арга барил гэдгийг ойлгосон. Ялангуяа энэ мэдлэгээ хүний нөөцийн ажилдаа ашиглаж, ажилтны туршлагыг сайжруулах, байгууллагын дотоод асуудлуудыг шинэ өнцгөөс харах боломжтойг олж харсан. Суралцсан зүйлээ өөртөө үлдээхийг хүсээгүй учраас багийнхаа зургаан гишүүнд UX дизайн болон "Design Thinking"-ийн талаар хоёр удаагийн сургалт зохион байгуулж, шинэ арга барилыг хамтдаа туршиж эхэлсэн.

Хөтөлбөрийн үеэрх спортын өдөрлөг, багийн үйл ажиллагаанууд биднийг нэг хамт олон болгож чадсан нь хамгийн дурсамжтай мөчүүдийн нэг байсан. Өнөөдөр ч би энэ хөтөлбөрөөс сурсан хэрэглэгч төвтэй хандлага, асуудал шийдвэрлэх арга барилаа ажил болон хувь хүний хөгжилдөө тууштай ашиглаж, илүү их үнэ цэн бүтээхийг зорьж байна.



93,926 удаа шалгалт өгөв

Оролцогчид “Google Career Certificate” хамгаалахын тулд нийтдээ 93,926 удаа шалгалт өгчээ. Уйгагүй хичээж, агуулгаа дахин судалж, шалгалтаа амжилттай давсан байна.



Advanced Data Analytics

“Advanced Data Analytics” хөтөлбөр нь их хэмжээний өгөгдөл дээр анализ хийх, бизнесийн шийдвэр гаргалтыг өгөгдлөөр дэмжих, машин сургалт болон урьдчилан таамаглах загварын суурь ойлголтыг практикт ашиглах чадвар эзэмшүүлэх ахисан түвшний сургалт юм.

Хөтөлбөрийн хүрээнд суралцагчид өгөгдлийн урьдчилсан дүн шинжилгээ (exploratory data analysis) хийх, статистикийн шинжилгээг ашиглан өгөгдлийн хандлагыг тодорхойлох, шугаман регрессийн загвар болон машин сургалтын загвар боловсруулах, комплекс өгөгдөл дээр ажиллах аргачлалуудыг сурна. Мөн A/B тест, өгөгдлийн дүрслэл, өгөгдлийн сторителлинг зэрэг аналитикийн орчин үеийн ур чадваруудыг хөгжүүлдэг.

Хөтөлбөр нь 200+ цагийн мэргэжлийн хичээл, практик даалгавар, сурсан зүйлээ бататгах жижиг төслүүдээс бүрдэх бөгөөд суралцагчид “Python, Jupyter Notebook, Tableau” зэрэг аналитикийн платформууд дээр бодит өгөгдөлтэй ажиллана. Сургалтын явцад өгөгдөлд анализ хийх, өгөгдлөөс дүгнэлт гарган үр дүнгээ оролцогч талуудад ойлгомжтой байдлаар тайлагнах практик ур чадвараа хөгжүүлдэг.

Түүнчлэн хөтөлбөрийн хүрээнд өгөгдлийг зөвхөн тайлбарлахаас гадна ирээдүйн хандлагыг таамаглах, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргах, аналитикийг бизнесийн стратегитай холбох сэтгэлгээг хөгжүүлдгээрээ онцлогтой.



Ш.Бат-Эрдэнэ:

**Шинэ мэдлэгээс гадна
шинэ боломж, шинэ харах
өнцөг авчирсан үнэ
цэнтэй туршлага болсон**



Би боловсролын салбарт дүн шинжилгээ, дата анализийн чиглэлээр ажилладаг. Технологийн хөгжлийн энэ үед тасралтгүй суралцах нь зайлшгүй хэрэгцээ болсон гэж боддог учраас мэдлэг, ур чадвараа ахиулж, ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх зорилгоор “Grow with Google Mongolia” хөтөлбөрийн “Data Analytics” чиглэлд суралцсан.

Энэ хөтөлбөр миний ажиллах арга барилд бодит өөрчлөлт авчирсан гэж хэлж болно.

Өмнө нь мэдээллийг ихэвчлэн тайлагнах түвшинд ашигладаг байсан бол одоо өгөгдлийн хандлага, уялдаа холбоо, шалтгаан үр дагаврыг тодорхойлж, нотолгоонд суурилсан дүн шинжилгээ хийх чадвар маань илүү хөгжсөн. Үүний үр дүнд байгууллагын үйл ажиллагаа болон салбарын бодлого, төлөвлөлтийг өгөгдөлд тулгуурлан үнэлэх, шийдвэр гаргагчдад илүү чанартай мэдээлэл бэлтгэх боломж бүрдсэн. Миний хувьд энэ мэдлэг, ур чадвар цаашдын карьер хөгжил болон ажлын бүтээмжид урт хугацааны үр нөлөө үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Мөн “Grow with Google Mongolia” зөвхөн мэргэжлийн мэдлэг олгодог сургалт биш байсан. Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан олон төрлийн арга хэмжээ, хамтын ажиллагаанд суурилсан орчин нь багаар ажиллах чадвар, нийгмийн оролцоог маань дэмжиж, олон салбарын залуусаас суралцах боломж олгосон. Тиймээс миний хувьд энэ хөтөлбөр шинэ мэдлэгээс гадна шинэ боломж, шинэ харах өнцөг авчирсан үнэ цэнтэй туршлага болсон.



Л.Жавзандулам:

Дижитал ур чадвараа хөгжүүлэхээр орсон ч сонирхлынхоо дагуу ажлын байртай болж, төсөөлснөөс их боломжийг нээж өгсөн



Би 2025 онд “Grow with Google Mongolia” хөтөлбөрт “Data Analytics” чиглэлээр хамрагдсан. Тухайн үедээ дижитал ур чадвараа хөгжүүлэх зорилготой байсан ч энэ хөтөлбөр надад илүү их боломж нээж өгсөн.

Сургалтын явцад ахисан түвшний өгөгдөл шинжилгээний ойлголтуудыг сурч, код бичиж үзэн, бодит төсөл дээр ажиллах туршлага хуримтлуулсан юм. Ялангуяа зочин илтгэгчдийн судалгааны ажлууд, салбарын мэргэжилтнүүдийн бодит туршлага надад маш их урам өгсөн.

Тэр урмаараа би сургалтын төгсгөлд ангийн багш Болортой холбогдож, компанид нь ажиллах хүсэлт гарган ярилцлагад орсон юм. Анх үйлдвэрлэлийн дадлага хийх зорилготой байсан ч сонирхол болон мэргэжлийн чиглэлтэй минь нийцсэн учраас шууд ажилд орж чадсан. Одоо би “Data Deus” компанид хичээлийнхээ хажуугаар ажиллаж, сурсан мэдлэгээ бодитоор хэрэгжүүлж байна.

Энэ хөтөлбөр надад мэдлэгээс гадна боломжийг өөрөө олж харж, ашиглах итгэл өгсөн. Их сургуулиа төгсөх үед онолын мэдлэг болоод бодит ажлын туршлага, салбарын хүмүүстэй хамтран ажилласан туршлагатай байна гэдэг надад ирээдүйдээ итгэх урам өгч байна.



Э.Оюунханд:

Хөтөлбөрт
хамрагдсанаар George
Washington, University of
Michigan зэрэг дэлхийн
шилдэг сургуулиудаас
тэтгэлэгтэй суралцах
урилга авсан



“Grow with Google Mongolia” хөтөлбөр амьдралд минь маш том эргэлт авчирлаа. Хөтөлбөрийн үр дүнд 2026 онд АНУ-ын George Washington, University of Michigan зэрэг дэлхийн шилдэг сургуулиудаас тэтгэлэгтэй суралцах урилга авсан юм.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдөх сертификат, багшийн маань оновчтой тодорхойлох захидал элсэлтийн комисст мэргэжлийн чадвар, суралцах идэвх зүтгэлийг минь батлан харуулсан гэж бодож байна.

Хичээлээр үзсэн өгөгдлийн цогц шинжилгээний аргачлалуудыг “AI Recommendation System” хөгжүүлэлтийн төсөлдөө шууд хэрэгжүүлсэн. RFM анализ, A/B тест болон ROI тооцоолол зэрэг өгөгдөлд суурилсан шинжилгээний аргачлалууд нь төслийн техникийн хэрэгжилтийг бизнесийн бодит үр өгөөжтэй уялдуулахад чухал нөлөө үзүүлсэн. Онолын мэдлэгээ практикт шилжүүлж, өгөгдлөөр дамжуулан шийдвэр гаргах арга барилд суралцсандаа сэтгэл хангалуун байна.

Хөтөлбөрийн явцад хамтран суралцагчдадаа зориулан мэдлэг хуваалцах боломж гарсан нь хамгийн сэтгэл догдлуулсан үе байсан гэж боддог. Мөн өөрийн туршлага, суралцах замнал болон эзэмшсэн техникүүдийг ажил дээрээ хэрхэн хэрэгжүүлж буйгаа бусдад танилцуулсан. Залуустаа бодит кэйсээр дамжуулан урам зориг өгч, салбарын мэдлэгээ хуваалцах нь хамтдаа хөгжих үнэ цэнтэй боломжийг олгосон юм. Цаашид “Data Scientist” чиглэлээр гүнзгийрүүлэн суралцаж, хиймэл оюунд суурилсан стратегийн шийдвэрүүдийг Монголынхоо технологийн салбарт нэвтрүүлэх зорилготой байна.




IT Automation with Python

“IT Automation with Python” хөтөлбөр нь гар ажиллагаатай, давтагддаг техникийн ажлуудыг автоматжуулж, системийг илүү хурдан, үр ашигтай ажиллуулах чадвар эзэмшүүлэх практик сургалт юм. Python ашиглан бодит ажлын процессыг хялбарчлах инженерийн сэтгэлгээг хөгжүүлнэ.

Хөтөлбөрийн хүрээнд суралцагчид Python програмчлалын суурь ойлголтоос эхлэн системийн даалгавруудыг автоматжуулах, скрипт боловсруулах, алдаа илрүүлж засах болон системийн доголдлыг оношилж шийдвэрлэх чадвар эзэмшинэ. Үүнээс гадна “Git, GitHub” ашиглан кодын хувилбарыг удирдах (version control), багийн орчинд код удирдах, хамтран хөгжүүлэлт хийх аргачлалуудад суралцдаг.

Хөтөлбөрийн хүрээнд суралцагчид автоматжуулалтын төсөл дээр ажиллахын зэрэгцээ үүлэн технологийн орчин (cloud environment), тохиргооны удирдлага (configuration management) болон DevOps-ийн суурь ойлголтуудыг практик байдлаар судална. 149 цагийн хичээлийн турш Linux орчинтой ажиллах, виртуал машин болон үүлэн дэд бүтцийг (cloud infrastructure) удирдах, дэд бүтцийг кодоор удирдах (Infrastructure as Code - IaC) аргачлалыг ашиглан системийн процессыг автоматжуулах үр чадварыг эзэмшдэг.

Сургалтын турш практик дадлага ажлууд (hands-on project) болон бие даасан төсөл дээр ажиллаж, бодит IT орчин дахь асуудлыг автоматжуулалт ашиглан шийдвэрлэх, системийн ажиллагааг оновчлох, цаг шаардсан процессыг автоматжуулах чадвараа хөгжүүлдэг.



Б.Амартүвшин:

Хөтөлбөр дууссаны дараа ч холбоотой байж, боломж, мэдээллээ хуваалцсаар байгаа нь үнэхээр том давуу тал


Би “Grow with Google Mongolia” хөтөлбөрийн “IT Automation with Python” чиглэлээр суралцсан. Хөтөлбөрт хамрагдах болсон гол шалтгаан маань мэргэжлээрээ илүү гүнзгийрэхийн зэрэгцээ танилын хүрээ, мэдлэгийн хүрээгээ тэлэх байсан. Мөн Google-ийн сертификат нь CV болон карьерын хувьд бодит ахиц өгнө гэж харсан. Хөтөлбөрийн хамгийн үнэ цэнтэй зүйл нь миний хувьд хамт олон байсан л даа. Ангийнхан, багш нар маань хөтөлбөр дууссаны дараа ч холбоотой байж, сар бүр уулзаж, боломж, мэдээллээ хуваалцсаар байгаа нь үнэхээр том давуу тал болж байгаа.

Сургалтын явцад би техникийн мэдлэгээс гадна, цагийн менежмент, багаар ажиллах, өөрийгөө илэрхийлэх чадвараа хөгжүүлсэн.

Даалгаврууд нэлээн шахуу байсан тул ажлынхаа хажуугаар амжуулахын тулд зохион байгуулалттай байх шаардлагатай болсон юм.

Багш нар маань ч бодит туршлагаасаа хуваалцаж, зарим тохиолдолд ажлын боломж санал болгож байсан нь урам өгсөн шүү. Одоо би Python дээрээ хиймэл оюун хөгжүүлэгчээр ажиллаж байгаа. Хөтөлбөрөөс авсан мэдлэг, орчин нь энэ шатанд хүрэхэд бодит нөлөө үзүүлсэн гэж боддог. Харилцааны ур чадварын сургалтууд, спортын өдөрлөг, үйл ажиллагаанууд зэрэг хичээлээс гадуурх үйл ажиллагаанууд бас надад их нөлөөлсөн шүү.

Танихгүй хүмүүсийн дунд орж, ижил сонирхолтой, идэвхтэй залуучуудтай танилцаж, хүрээллээ тэлсэн. Тэр дундаа спортын наадам миний төрсөн өдөртэй давхацсан нь хөтөлбөрийн хамгийн сайхан дурсамж минь болж үлдсэн. Өөрийгөө хөгжүүлж, олон салбарын хүмүүсийн өнцгөөс асуудалд хандаж сурахыг хүсвэл энэ хөтөлбөрт заавал хамрагдах хэрэгтэй.



Б.Амартүвшин:

Хөтөлбөр дууссаны дараа ч
холбоотой байж, боломж,
мэдээллээ хуваалцсаар байгаа
нь үнэхээр том давуу тал



Б.Баярצעэг:

Хөтөлбөр надад дан ганц техник ур чадвар биш, идэвхтэй хамт олон, суралцах орчныг бэлэглэсэн



Би биологич мэргэжилтэй, магистр, докторын зэргээ Унгар улсад хамгаалсан. Судалгааны ажлаа фармакоинформатик-ийн чиглэлээр хийсэн юм. Гэхдээ биологийн суурьтай хүний хувьд код бичих чадвараа системтэй хөгжүүлэх шаардлагатай байсан тул “Grow with Google Mongolia” хөтөлбөрийн IT Automation with Python ангид элссэн.

Өөрөө бие даан сурах гэж оролдож байсан ч ахиц удаан байсан учраас мэргэжлийн орчинд, багш, анги хамт олонтой сурахаар шийдсэн л дээ. Хөтөлбөрийн туршид Python хэлээр код бичих, автоматжуулах, бодит асуудлыг кодоор шийдэх чадвар маань эрчимтэй сайжирсан. Ялангуяа багийнхантайгаа хамт “PhytoDock” төслийг боловсруулсан нь миний хувьд том туршлага болсон юм. Монголын уламжлалт анагаах ухаанд ашиглагддаг ургамлуудаас ялгаж авсан химийн нэгдлүүдийг ямар өвчинд ашиглах боломжтой вэ гэдгийг компьютер симуляцаар урьдчилан таамаглаж, лабораторийн туршилтад бэлтгэх автоматжуулсан систем боловсруулсан юм. Тухайн үед манай баг 2-р байрт шалгарсан. Энэ төслөө цааш үргэлжлүүлэн, докторын дараах судалгааны 10 сая төгрөгийн тэтгэлэг авч, одоо веб платформ болгон хөгжүүлж байна. Тэгэхээр сургалтаас авсан мэдлэг маань судалгааны ажлыг минь улам гүнзгийрүүлж, шат ахиулсан гэж хэлж болно.

Үүнээс гадна “Grow with Google Mongolia” надад дан ганц техник ур чадвар биш, идэвхтэй хамт олон, суралцах орчныг бэлэглэсэн. Ер нь шинжлэх ухааны салбарын хүн IT чиглэлийн сургалтад суух нь хол юм шиг санагдаж болох ч өнөөдөр технологи бүх салбарт зайлшгүй хэрэгтэй болсон шүү дээ. Тиймээс аль ч чиглэлийн мэргэжилтэн суралцаж болно. Гол нь тууштай байж, чалленжүүдэд заавал оролцох хэрэгтэй. Тэнд л сурсан зүйлээ бодит асуудал дээр хэрэгжүүлж, өөрийн болгож чадна.



О.Болор-Эрдэнэ:

Өөртөө итгэлтэй болж,
сурсан мэдлэгээ ашиглан
төгсөлтийн ажлаа хийж,
мэргэжлийн дадлагаа
амжилттай хамгаалсан



Намайг Болор-Эрдэнэ гэдэг. Би МУИС-ийн Баруун бүсийн сургуулийн төгсөх курсийн оюутан. Би 2025 онд “Grow with Google Mongolia” хөтөлбөрт IT Automation with Python чиглэлээр хамрагдсан.

Анх өөрийгөө сорьж, танилцуулга бичлэгээ илгээхдээ их эргэлзэж байсан. “Чадахгүй байх даа”, “намайг яаж хүлээж авах бол” гэсэн бодлууд байнга төрдөг байлаа. Гэхдээ айдсаа давж, оролдоод үзэхээр шийдсэн нь миний хувьд хамгийн чухал алхам болсон. Миний тэнцсэн анхны тэтгэлэгт хөтөлбөр байсан юм.

Сургалтын явцад би техник ур чадвараас гадна, ажлаа автоматжуулах, асуудлыг олон өнцгөөс харах, өөр салбаруудыг сонирхох сэтгэлгээнд суралцсан. Алслагдсан бүсээс оролцож байсан ч манай ангийнхан маш хүчтэй комьюнити үүсгэж, бие биедээ урам өгдөг орчин бүрдсэн. Төгсөлтийн өмнөх Pitch Day, хамтдаа хийсэн төслүүд болон харилцаа хандлага гээд хөтөлбөрийн бүх зүйл надад хамгийн гүн сэтгэгдэл үлдээсэн.

Миний хувьд энэ хөтөлбөрөөр өөртөө бий болгож чадсан хамгийн том өөрчлөлт нь өөртөө итгэх итгэл байсан гэж бодож байна. Одоо би төгсөх курсийн оюутан, хөтөлбөрийн хугацаанд сурсан мэдлэгээ ашиглан төгсөлтийн ажлаа хийж, мэргэжлийн дадлагаа амжилттай хамгаалсан.



А.Ариунгоо:

Хөтөлбөрөөс олж авсан ур чадвараа биоинформатикийн хичээл судлахад ашиглаж байна. “Grow with Google Challenge”-д 2-р байр эзэлсэн төслөө үргэлжлүүлэн хөгжүүлж, Шинжлэх ухааны академид судалгаа хийж байна



Би 2025 онд “Grow with Google Mongolia” хөтөлбөрт IT Automation with Python чиглэлээр хамрагдсан. Анх огт програмчлалын суурьгүй байж Python-ын ахисан түвшний ангид орсон нь амар байгаагүй. Эхэндээ ойлгоход хэцүү байсан ч танхимын хичээл дээр сайн асуугаад, бага багаар ойлгож сурсаар сууриа тавьж чадсан. Энэ суурь мэдлэг маань одоо биоинформатикийн хичээл судлах, орчуулга хийхэд шууд хэрэг болж байна.

Сургалтаар сурсан зүйлс маань зөвхөн онолын түвшинд үлдээгүй. Python-ын мэдлэгээ ашиглан япон хэлээрх эх сурвалжаас биологийн мэргэжлийн хичээл орчуулж, оюутнуудад хүргэж байна. Мөн хөтөлбөрийн үеэр оролцсон “Grow with Google Challenge” тэмцээнд “PhytoDock” төсөл дээр ажиллаж, шинээр сурсан мэдлэгээ шууд туршсан. Манай баг 2-р байр эзэлж, төслөө үргэлжлүүлэн хөгжүүлсээр одоо Шинжлэх Ухааны Академид судалгаа хийж байгаа.

Миний хувьд энэ хөтөлбөрийн үнэ цэн нь “мэдэхгүй”-гээс эхлээд бодит хэрэглээ рүү шилжих боломж байсан. Одоо би химийн инженерчлэлийн чиглэлээр багшлахын зэрэгцээ хиймэл оюун болон Python-ыг өдөр тутмын ажилдаа ашиглаж байна.



Б.Наранцогт:

Хөтөлбөрийн ачааар
“эмч-инженер” болох
зорилгодоо илүү ойртсон



Би хүний их эмч мэргэжилтэй, мэс заслын чиглэлээр олон жил ажилласан. Гэхдээ “Мэс засал гэдэг бас нэг инженерийн ухаан” гэсэн багшийн маань үг намайг бага насны мөрөөдөл рүү минь буцааж аваачсан юм. Ингээд анагаах ухаан, технологийг хослуулах хүсэлдээ хөтлөгдөн програмчлалын чиглэлээр сурч, өнөөдөр Pinecone Academy-д багшилж, хөгжүүлэгчээр ажиллаж байна.

“Grow with Google Mongolia” хөтөлбөрийн IT Automation with Python сургалтад хамрагдсан нь эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн өгөгдөл боловсруулахад шаардлагатай Python мэдлэгээ илүү системтэй хөгжүүлэх зорилготой байсан юм.

Анхны танхимын хичээл дээр өөрийгөө эмч гэж танилцуулахад ангийнхан, багш нар хүртэл гайхаж байсныг одоо ч тод санадаг юм. Тэр үед өөрийгөө байх ёсгүй газраа байгаа юм шиг мэдэрсэн ч удалгүй энэ хөтөлбөрийн хамгийн том үнэ цэнийг ойлгосон. Технологийн салбарт ажиллаж буй хүмүүстэй танилцаж, тэдний сэтгэлгээ, ажиллах арга барилаас суралцахын зэрэгцээ “Python, Cloud Server, автоматжуулалт” зэрэг үр чадвараа бодитоор хөгжүүлж чадсан. Урьд нь зүгээр ашигладаг байсан платформуудынхаа цаана юу болж байгааг ойлгож, бүр өөртөө зориулсан жижиг код бичигч туслах хүртэл хийж үзсэн.

Миний хувьд тус хөтөлбөр “эмч-инженер” болох зорилгодоо илүү ойртсон аялал байсан гэж хэлж болно. Одоо эрүүл мэндийн салбарт хиймэл оюун болон технологийн шийдэл нэвтрүүлж, эмч нарын өдөр тутмын ажлыг хөнгөвчлөх, сургалтыг илүү үр дүнтэй болгох зорилготой ажиллаж байна. Энэ хөтөлбөр надад шинэ мэдлэгээс гадна ижил хүсэл тэмүүлэлтэй хүмүүсийн хүрээлэл, өөрийгөө улам хөгжүүлэх итгэл өгсөн гэж боддог.



Г.ОТГОНШИГИГ:

“Grow with Google Mongolia” хөтөлбөр өөртөө итгэх итгэлээ дахин олоход минь тусалсан



Би мэдээллийн системийн мэргэжилтэй, өгөгдлийн шинжлэх ухаанаар магистр хамгаалсан. Өмнө нь төслийн менежер, IT support, Back-end хөгжүүлэгчээр ажиллаж байсан ч гэр бүлээ сонгон карьераа түр хойш тавьж, одоо хоёр хүүхдээ асарч байгаа ээж.

Хиймэл оюун эрчимтэй хөгжиж байх үед ажлаасаа гарсан болохоор хааяа нийгмээс тасарчихсан юм шиг мэдрэмж төрдөг байлаа. Тиймээс өөрийгөө хөгжүүлэх, шинэ хүмүүстэй танилцах, салбарынхаа өөрчлөлтөөс хоцрохгүй байх хүсэлдээ хөтлөгдөн “Grow with Google Mongolia” хөтөлбөрт элссэн юм.

Сургалтын явцад Python-ийн мэдлэгээ сэргээж, “IT Automation, GitHub, Virtual Machine” зэрэг шинэ чадваруудаа ахиулсан. Гэхдээ миний хувьд хамгийн том ололт нь техник ур чадвараас илүү удаан бодож явсан нэг санаагаа бодит ажил болгох зориг олсон явдал байсан. Хүүхдээ асарч гэртээ байдаг ээжүүдийг хооронд нь холбох апп хийх санаагаа 6 жил дотроо тээсэн ч хэрэгжүүлж зүрхэлдэггүй байлаа. Харин “Grow with Google Challenge” тэмцээний үеэр энэ санаагаа ангийнхандаа хэлж, найман хүний бүрэлдэхүүнтэй баг болж хөгжүүлж эхэлсэн нь миний хувьд том эргэлтийн цэг болсон.

Мөн энэ хугацаанд өөрийгөө илэрхийлэх шинэ алхам хийж, “codingmom_оно” нэртэй хуудсаа нээн суралцаж буй туршлагаа хуваалцаж эхэлсэн. Хөтөлбөрийн комьюнити, багш нар, ангийнхан маань миний төсөөлж байснаас ч илүү дэмжлэг үзүүлсэн. Миний хувьд “Grow with Google Mongolia” бол хүүхдээ өсгөхийн зэрэгцээ мөрөөдөл, мэргэжлээ дахин сэргээж болохыг сануулсан үнэ цэнтэй боломж байсан шүү.



AI Essentials

“AI Essentials” хөтөлбөр нь хиймэл оюуныг өдөр тутмын ажил, бизнесийн шийдвэр гаргалт, бүтээлч процесстoo бодитоор ашиглах чадвар эзэмшүүлэх практик сургалт юм. Программчлалын суурь мэдлэг шаардахгүйгээр хиймэл оюуныг ажлын бүтээмж нэмэгдүүлэх “хувийн туслах” болгон ашиглах арга барилд төвлөрдөг.

Хөтөлбөрийн хүрээнд суралцагчид “generative AI” хэрэгсэл ашиглан тайлан боловсруулах, контент бүтээх, судалгаа нэгтгэх, имэйл болон бизнесийн бичиг баримт боловсруулах, төлөвлөгөө хийх зэрэг өдөр тутмын ажлуудаа автоматжуулах чадварыг эзэмшинэ. Мөн “effective prompting” буюу хиймэл оюунд оновчтой заавар өгөх, хиймэл оюунаас гарсан үр дүнг хянах, хиймэл оюуныг хариуцлагатай ашиглах аргачлалуудад суралцдаг.

53 цагийн сургалтын агуулгад танхимын хичээл, Coursera онлайн хичээл бие даасан болон багийн практик даалгаврууд багтах бөгөөд суралцагчид хиймэл оюун ашиглан санаагаа бүтээгдэхүүн болгох, хувийн болон бизнесийн хэрэглээнд ажлын процессыг автоматжуулах, мэдээллийг илүү хурдан боловсруулах, бүтээлч шийдэл гаргах туршлага хуримтлуулна.

Түүнчлэн хиймэл оюуны зохистой хэрэглээ болох хиймэл оюуны боломж, хязгаарлалт, нэг талт байдлаас үүсэх эрсдэл, мэдээллийн найдвартай байдлыг таньж, дүгнэх чадварыг хөгжүүлдэг нь хөтөлбөрийн чухал хэсэг юм.



Г.Ундрам:

Хиймэл оюун ашиглаж
сурснаар ажлаа гурав
дахин хурдан хийдэг
болсон



Би график дизайн, маркетингийн чиглэлээр чөлөөт уран бүтээлчээр ажилладаг. Ажлаа илүү хөнгөвчлөх, мөн өөр өөр салбарын залуустай танилцах зорилгоор “Grow with Google Mongolia” хөтөлбөрт хамрагдсан юм.

Хөтөлбөрийн хугацаанд хиймэл оюуны талаарх шинэ мэдээллүүдийг цаг тухайд нь авч, хичээл дээрх чалленжүүдэд оролцож явсан нь надад их өгөөжтэй байсан.

Хамгийн том өөрчлөлт нь ажлын арга барил дээр гарсан шүү. Өмнө нь нэлээд хугацаа зарцуулдаг байсан драфтуудаа одоо маш хурдан гаргадаг болж, ажлын цагаа бараг гурав дахин хэмнэх болсон. Мөн рийл контентуудаа яг төсөөлсөн санаагаараа илүү бүтээлчээр хийх боломжтой болсон нь миний ажлын чанарт шууд нөлөөлсөн.

Хөтөлбөрөөс сурсан зүйлээ бодит ажил болгож чадсан нь бүр үнэ цэнтэй. Би нөхөртэйгөө хамтран EQ/IQ, хувь хүний зан төлөв болон хууль эрх зүйн чиглэлийн платформыг нэг ч мөр код бичилгүйгээр хиймэл оюуны тусламжтайгаар хөгжүүлж, ашиглалтад оруулсан.

Хөтөлбөрийн хамгийн сонирхолтой хичээл нь “Vibe Coding” байсан. Өмнө нь вебсайтын жижиг өөрчлөлт хийхийн тулд хөгжүүлэгчидтэй удаан хугацаанд ойлголцож, хүлээх шаардлагатай болдог байсан бол одоо кофе ууж суух зуураа хиймэл оюунтай чатлаад л хүссэн засвараа хийдэг болсон.



AI for Business

“AI for Business” хөтөлбөр нь хиймэл оюуныг бизнесийн бодит үйл ажиллагаанд нэвтрүүлж, ажлын бүтээмж, шийдвэр гаргалт, стратегийн төлөвлөлтийг илүү ухаалаг түвшинд хүргэхэд чиглэсэн дунд түвшний сургалт юм.

Хөтөлбөрийн хүрээнд суралцагчид хиймэл оюуныг байгууллагын өсөлт, процесс оновчлолын хэрэгсэл болгон ашиглах аргачлалд суралцана. Тайлан боловсруулах, өгөгдлийн дүн шинжилгээ хийх, бизнесийн судалгаа нэгтгэх, үйл ажиллагааны процессыг автоматжуулах, харилцаа болон төлөвлөлтийг оновчлох зэрэг бодит ажлын урсгалууд дээр хиймэл оюуны хэрэгслүүдийг бага зардлаар, оновчтой, үр ашигтай ашиглах чадвар эзэмшинэ.

69 цагийн цахим, танхим хосолсон хичээлээр суралцагчид хиймэл оюуныг бизнесийн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрхэн бодитоор ашиглахыг 100% практик арга барилаар суралцана. Хиймэл оюунаар ажлын урсгалыг автоматжуулах, дотоод болон гадаад хэрэгцээнд зориулсан веб, апп бүтээх, бизнесийн оновчтой стратеги тодорхойлох зэрэг бодит практикт, суралцдаг.

Хөтөлбөрийн онцлог нь ямар нэгэн программчлалын гүнзгий мэдлэг шаардахгүйгээр хиймэл оюуныг бизнесийн хэрэгцээнд нийцүүлэн ашиглах практик сэтгэлгээг хөгжүүлдэгт оршино.



Б.Энхзаяа:

Хөтөлбөрөөс сурсан мэдлэгээ ашиглан 1,000 гаруй багшийн ажлыг 10 дахин хөнгөвчилсэн



Би Дижитал Эдү Менежмент ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг. Надад “Маш сайн систем хөгжүүлээ ч хэрэглэгч түүнийг ашиглаж мэдэхгүй бол боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах зорилгодоо хүрч чадахгүй” гэсэн бодол үргэлж байдаг.

Тиймээс “Grow with Google Mongolia” хөтөлбөрөөс сурсан мэдлэг, арга барилаа байгууллагынхаа үйл ажиллагаанд шууд хэрэгжүүлж, боловсролын салбарын хэрэглэгчдээ чадавхжуулах ажлыг эхлүүлсэн.

Бид “Google Gemini, NotebookLM, Google Vids” зэрэг хиймэл оюуны хэрэгслүүдийг ашиглан багш, боловсролын байгууллагын мэргэжилтнүүдэд зориулсан ахисан шатны сургалтыг боловсруулж, Дархан-Уул, Хэнтий, Баянхонгор, Сүхбаатар аймаг болон нийслэлийн сургуулиудын нийт 1,000 орчим багш, мэргэжилтнүүдийг хамруулсан. Сургалтын хүрээнд багш нар хиймэл оюун ашиглан хичээлийн төлөвлөгөө, үнэлгээний материал, видео болон интерактив контент бүтээж, түүнийгээ “eSchool” системдээ ашиглах арга барилд суралцсан юм.

Хөтөлбөрийн дараах сэтгэл ханамжийн судалгаагаар энэхүү аргачлал нь багш нарын хичээл бэлтгэх хугацааг 10 дахин хэмнэж байгааг суралцагчид онцолсон байсан шүү. “Grow with Google Mongolia” хөтөлбөрт хамрагдсан маань байгууллагын соёл, бүтээмж болон харилцагчдадаа хүргэх боловсролын үйлчилгээний чанарт бодит өсөлт авчирсан өөрчлөлтийн эхлэл болсон гэж бодож байна.



Г.Монголхүү:

Энэхүү хөтөлбөр надад технологийн суурь ойлголтыг зөв суулгаж, цаашид өөрийгөө бие даан хөгжүүлэх урам зоригийг өгсөн



“Grow with Google Mongolia” хөтөлбөрт хамрагдахаас өмнө би хиймэл оюуныг зөвхөн ChatGPT, Gemini зэргээр л төсөөлдөг байлаа. Ер нь нарийн сайн ойлголтгүй, ажилд маань хэрэг болох болов уу гэсэн хүлээлттэй л сургалтаа эхлүүлсэн юм.

Гэтэл танхимын хичээлүүд маш сонирхолтой, багш нар маань ч мундаг, чадвартай залуус байсан болохоор би өөрөө их идэвхтэй суралцаж, олон шинэ мэдээлэлтэй болсон байна. Хөтөлбөрөөр хиймэл оюуны боломж асар өргөн болохыг, ажил хөнгөвчлөх олон төрлийн тусгай хэрэгслүүд байдгийг мэдэж авлаа. Ялангуяа хиймэл оюун ашиглан программчлалын код бичиж болдгийг мэдсэн нь хамгийн сонирхолтой байсан бөгөөд сургалтын дараа түүнийгээ шууд ажил дээрээ бодитоор хэрэгжүүлж эхэлсэн маань маш том дэмжлэг болж байна.

Хөтөлбөрт хамрагдсаны дараа миний харах өнцөг эрс өөрчлөгдсөн. Одоо ажил дээр ямар нэгэн даалгавар биелүүлэхдээ хамгийн түрүүнд “Үүнийг хиймэл оюун ашиглан яаж илүү хялбар, хурдан хийж болох вэ” гэж боддог болсон байна.

Энэхүү хөтөлбөр надад технологийн суурь ойлголтыг зөв суулгаж, цаашид өөрийгөө бие даан хөгжүүлэх урам зоригийг өгсөн. Хөтөлбөрөөр заалгасан зүйлээр зогсохгүй, ажил дээр тулгарч буй асуудал бүрд тохирох шинэ шийдэл, хэрэгслүүдийг өөрөө үргэлжлүүлэн хайж, судалдаг бүтээлч зуршилтай боллоо. Цаашид тасралтгүй суралцаж, ур чадвараа ахиулах урт хугацааны шинэ замыг нээж өгсөн нь миний хувьд хамгийн бодит үр дүн, өөрчлөлт юм.



Б.Хуншагай:

Хиймэл оюуны тусламжтайгаар ажлын хандлага маань даалгавар гүйцэтгэхээс үнэ цэн бүтээх рүү шилжиж, бүх заавар, тайлангаа бүрэн шинэчиллээ



“Grow with Google Mongolia” хөтөлбөр Нэткапитал Санхүүгийн Группийн ажилтнуудад хувь хүний дижитал ур чадварыг хөгжүүлэх, ажлын арга барилыг өөрчлөх шинэ боломжийг нээлээ.

Манай компанийн эрхэм зорилго “AI first company” бөгөөд бид хиймэл оюуныг өдөр тутмын ажилдаа ашиглаж, бүтээмжээ өсгөхөөр зорьж байгаа тул төв оффисын ажилтнуудынхаа 50%-ийг сургалтад хамруулсан. Хөтөлбөрийн дараа ажилчдын дижитал ур чадвар, өгөгдөлд суурилсан сэтгэлгээ, өдөр тутмын ажлын арга барилд бодит ахиц гарсан байна. Тухайлбал, дижитал хэрэгслүүдийг илүү үр ашигтай ашиглах, мэдээлэлд суурилан шийдвэр гаргах, ажлаа системтэй төлөвлөх чадвар сайжирсан. Мөн хиймэл оюун болон автоматжуулалтын хэрэгслүүдийг ажилдаа ашиглах соёл идэвхжиж, асуудал шийдвэрлэх хандлага маань даалгавар гүйцэтгэхээс үр дүн болон үнэ цэн бий болгох руу өөрчлөгдсөн.

Энэ дундаас “AI Essentials” болон “AI for Business” сургалтууд хамгийн үнэ цэнтэй байсан гэж хэлж болно. Сургалтад хамрагдсанаар бүгд “prompt” бичиж сурсан төдийгүй хиймэл оюуны хэрэгслүүдтэй танилцаж, өдөр тутмын ажилдаа ашиглаж эхлээд байна. Яг одоогийн байдлаар бүх заавар, журам, тайлангаа хиймэл оюунаар хийлгэж, бүрэн шинэчлээд байна. Энэхүү ур чадварын сайжруулалт нь байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд шууд эерэг нөлөө үзүүлж, ажлын процесс оновчтой болж, шийдвэр гаргалтын хурд нэмэгдсэн. Үүний зэрэгцээ багийн хамтын ажиллагаа сайжирч, гүйцэтгэл үр ашигтай болсон нь нийт бүтээмж өсөхөд нөлөөлсөн бөгөөд давхардсан ажил багасаж, автоматжуулалтын түвшин дээшилсэн.

“Grow with Google Mongolia” хөтөлбөрийн багш нарын сэтгэгдэл



У.Ганбаяр

“Cybersecurity” ангийн
2024-2026 оны үндсэн багш

Кибер аюулгүй байдлын мэргэжил дэлхийд чухал, ховор гэж тооцогддог. Оксфордын судлаач нарын хийсэн судалгааны үр дүнд Монгол Улсад уг чиглэлд мэргэжилтэн маш дутмаг байгааг тайлагнасан байдаг. “Grow with Google Mongolia”-ийн Кибер аюулгүй байдлын хөтөлбөр нь зах зээлд үүсээд буй хэрэгцээ, шаардлагыг нөхөхөд маш том дэмжлэг үзүүлж байна. Түүнчлэн төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс аюулгүй байдлын чиглэлд суралцахад тохирсон агуулгатай байгаа нь кибер аюулгүй байдлын соёлыг бий болгоход мөн түлхэц болж байгаа.



Ж.Болор

“Advanced Data Analytics &
Data Analytics” ангийн
2025-2026 оны үндсэн багш

Өнөөдөр бараг бүх салбар байгууллагууд өгөгдөлд суурилсан шийдвэр гаргах шаардлагатай болж байгаа ч ийм ур чадвартай хүний нөөц хангалтгүй хэвээр байна. Харин энэ хөтөлбөрөөр дамжуулан суралцагчид техникийн ур чадвараа сайжруулж, бизнесийн асуудлыг өгөгдлөөр ойлгож, тайлбарлаж, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх чадварт суралцаж байна. Энэ нь залуусын хөдөлмөрийн зах зээл дэх өрсөлдөх давуу тал болж байна.



Ж.Батчимэг

“Project Management” ангийн
2025-2026 оны үндсэн багш

Өнөөдөр дижитал ур чадвар боловсролын салбарт сонголт биш, суурь хэрэгцээ болоод байна. Монгол залууст олон улсын зөв арга зүй, хэрэгслийг нь өгчихвөл ямар ч төслийг түүртэлгүй удирдах чадвартай. Хөтөлбөрийн явцад суралцагчид төслийн төлөвлөлт, системчлэлээс бэргэхээ больж, багаар ажиллах, өөрсдийн санааг хамгаалах тал дээр илүү зоримог, идэвхтэй болж өөрчлөгдсөн. Миний хувьд ч хиймэл оюуныг төслийн удирдлагад хариуцлагатай ашиглах зэрэг дижитал ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх хөшүүрэг боллоо.



Э.Цогт

“UX Design” ангийн 2024
оны үндсэн багш

Миний хувьд UX дизайны ур чадварыг хэрэглэгчийн өнцгөөс асуудлыг ойлгож шийдвэрлэх сэтгэлгээ гэж харуулахыг зорьдог. Тиймээс ч тус хөтөлбөрт багшлах хугацаандаа онолын мэдлэгээс гадна зах зээл дээрх бүтээгдэхүүний бодит жишээ, багийн хамтын ажиллагаа, хэрэглэгчийн судалгааны ач холбогдлыг түлхүү онцолдог байлаа. Уг хөтөлбөр надад нэг талаас өөрийн мэдлэг, туршлагыг бусадтай хуваалцах боломж болсон бол нөгөө талаас өөрийгөө дахин хөгжүүлэх, Google-ийн албан ёсны хөтөлбөрийн хүрээнд ажилласан учраас олон улсын түвшний агуулга, аргачлалтай илүү гүнзгий танилцаж, UX дизайны мэдлэгээ системтэйгээр эргэн харж, нарийвчлан бататгах боломж болсон юм. Мөн шинэ үеийн суралцагчдын хүсэл тэмүүлэл, суралцах арга барилаас олон зүйлийг олж харсан нь миний хувьд үнэ цэнтэй туршлага болсон.



М.Отгонтунгалаг

"Digital Marketing & E-Commerce" ангийн 2026 оны үндсэн багш

"Digital Marketing & E-Commerce" хөтөлбөрт багшлахдаа бодит туршлага, практик кэйсүүд дээр тулгуурлан хичээлээ хүргэхийг зорьсон. Сургалтын эхэнд суралцагчид маркетингийг зөвхөн социал медиагаар төсөөлдөг байсан бол төгсөхдөө стратеги, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтын ач холбогдлыг ойлгож эхэлсэн. Энэ нь тэдний мэргэжлийн сэтгэлгээнд том өөрчлөлт авчирсан гэж боддог. Хөтөлбөр залуусын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, шинэ боломжуудыг нээж байна. Ялангуяа нэг суралцагч сургалтын хугацаанд 30 сая төгрөгийн гэрээ байгуулсан нь хамгийн бахархалтай мөчүүдийн нэг байлаа. Багшлах явцдаа би ч мөн мэдлэгээ шинэчилж, олон салбарын хүмүүстэй хамтран суралцах үнэ цэнтэй туршлага хуримтлуулсан.



М.Дөлгөөнбаяр

"UX Design" ангийн 2025-2026 оны үндсэн багш

UX дизайныг олон хүн эхэндээ дэлгэцийн загвар, харагдах байдалтай холбож ойлгодог байсан бол хөтөлбөрийн төгсгөлд суралцагчид аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний гол үнэ цэн нь асуудлыг хэр оновчтой шийдэж байгаад оршдог гэдгийг ойлгож эхэлсэн. Хичээлийн явцад бид дизайны аргачлалаас гадна хэрэглэгчийн сэтгэл зүй, харилцан үйлчлэл, асуудал шийдэх сэтгэлгээнд төвлөрсөн. Мөн хиймэл оюуны эрчимтэй хөгжлийн үед дизайнерууд "хэрхэн хиймэл оюунаас ялгарч үнэ цэн бүтээх вэ" гэх асуултад ангиараа хариулт хайх нь бидний хамгийн том бэрхшээл байсан юм. Гэхдээ суралцагчид ажлын ачаалал, хувийн амьдралынхаа хажуугаар 100 гаруй цагийн сургалтаа дуусгаж, шинэ салбарт хөл тавих суурь ур чадвараа бодитоор бүтээж чадсанд баяртай байна.



Э.Өсөхбаяр

“AI Essentials & AI for Business” ангийн 2026 оны үндсэн багш


Хөтөлбөрийн эхэнд суралцагчдаас хиймэл оюуныг хэрхэн ашиглаж, хэдэн төгрөг зарцуулж байгаа талаар судалгаа авсан юм. Тэд ихэвчлэн танин мэдэхүйн түвшинд хиймэл оюуныг ашигладаг бөгөөд суралцагчдын 60% нь хувь хүний сарын 20\$, байгууллагын хувьд сарын 100-200\$ зарцуулдаг байсан. Харин хөтөлбөрийн төгсгөлд хиймэл оюуныг байгууллагын хэмжээнд бизнесийн үйл явцаа сайжруулахад оновчтой ашиглаж сурсан юм. Тухайлбал, хэрэглэгчийн зан төлөв, худалдан авах дадлыг таних, хэрэглэгчийн мэдээлэл дээр анализ хийх, хүний нөөц болон бусад чиг үүргийг хялбаршуулахын сацуу байгууллагын хиймэл оюуны стратеги, төсөвт өртгийг тодорхойлсон. Дэлхий дахинаа бүтээмжийн уралдаан явагдаж буй энэ цаг үед хиймэл оюуны ангид хичээл зүтгэл гарган суралцсан суралцагчид ажлын байрандаа илүү үнэ цэнтэй ажилтан болж чадсан гэж харж байна.



М.Тэмүүлэн

“Digital Marketing & E-Commerce” ангийн 2024-2025 оны үндсэн багш

Залуусын өрсөлдөх чадварын хувьд энэхүү хөтөлбөр маш олон давуу талыг бий болгож байна. Хэдийгээр богино хугацаанд хэрэгжиж буй сургалт боловч суралцагчид онолын мэдлэгээс гадна Монголын болон олон улсын зах зээлд цахим худалдаа эрхлэх, бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлах, дижитал маркетингийн стратеги боловсруулах, орчин үеийн маркетингийн хэрэгслүүдийг ашиглах суурь ур чадваруудыг сурч мэдэж байна. Үүний үр дүнд суралцагчид өөрсдийн карьерыг шинэ чиглэлд хөгжүүлэх, хөдөлмөрийн зах зээл дээр илүү өрсөлдөх чадвартай болж, хувийн бизнесээ эхлүүлэх эсвэл өргөжүүлэх боломжийг олж авч байгаа нь энэхүү хөтөлбөрийн хамгийн бодит бөгөөд үнэ цэнтэй үр нөлөө гэж харж байна.



С.Дөлмандах

“IT Automation with Python”
ангийн 2026 оны үндсэн багш

IT Automation with Python хөтөлбөрөөр дамжуулан суралцагчдад компьютер, IT системийн суурь ойлголт болон ажлыг автоматжуулах сэтгэлгээг төлөвшүүлэхийг зорьсон. Хөтөлбөрийн төгсгөлд суралцагчид өдөр тутмын ажлаа автоматжуулах боломжийг олж харж, бодитоор хэрэгжүүлж эхэлсэн нь хамгийн тод өөрчлөлт байлаа. Энэ нь тэдний бүтээмжийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн зах зээл дэх өрсөлдөх чадварыг нь сайжруулахад хувь нэмэр оруулсан гэж бодож байна. Мөн өөр өөр мэргэжлийн хүмүүстэй ажиллах нь надад шинэ өнцөг, шинэ санаа өгсөн. Ялангуяа эмч мэргэжилтэй мөртлөө IT чиглэлээр хөгжиж, хоёр салбарыг холбох шийдэл эрэлхийлж байсан суралцагчийн хичээл зүтгэл бахархал төрүүлсэн.



Б.Мөнх-Эрдэнэ

“IT automation with
Python” ангийн 2024-2025
оны үндсэн багш

Шинжлэх ухаан, инженерчлэл, технологийн ур чадварыг эзэмшихэд суралцагчаас маш их хичээл зүтгэл, тууштай байдал шаарддаг. Богино хугацаанд гүнзгий ур чадвар эзэмшихэд зөвхөн Coursera-гийн хичээл үзэхэд хангалтгүй гэж үзсэн тул суралцагчдад тус салбарын суурь ойлголтыг маш сайн өгөх, цаашид бие даан суралцах чадвартай болгоход түлхүү анхаарч ажилласан юм. “Grow with Google” хөтөлбөр нь Монголын хөдөлмөрийн зах зээлд бодит үнэ цэн бий болгож байна. Өнөөдөр технологи, өгөгдөл, автоматжуулалт, дижитал хэрэгслүүдийг ойлгож ашиглах чадвар зөвхөн IT салбарын хүмүүст гэхгүй бүх мэргэжилтэнд хэрэгтэй чадвар боллоо. Энэхүү хөтөлбөр нь мэргэжлээ хөрвүүлэх хүсэлтэй залууст олон улсын түвшний мэдлэг эзэмшиж, өөрийн карьерын шинэ боломжийг нээх, хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай чадварлаг боловсон хүчин болох суурийг тавьж өгч байна.



Д.Хүрэлтогоо

“Project Management”
ангийн 2024 оны үндсэн
багш

Төслийн удирдлага бол зөвхөн баримт бичиг боловсруулж, тайлан гаргадаг ажил биш юм. Харин асуудлыг системтэй шийдэх, баг удирдах, өөрчлөлтийг хэрэгжүүлэх арга барил гэдгийг суралцагчид маань хөтөлбөрөөр дамжуулан ойлгож авсан. Анх төслийн удирдлагын талаарх ойлголтын ялгаа их байсан ч сургалтын явцад тэд төслийн төлөвлөгөө гаргах, эрсдэлээ тооцоолох, багтайгаа хамтран ажиллах, шийдвэр гаргах хүртэлх цогц ойлголттой болж чадсан юм. Өөр өөр салбар, нас, туршлагатай хүмүүс нэг ангид цугларч, хичээлийн цагаас гадуур ч хамтдаа суралцаж, олон зүйлийн талаар хэлэлцэн шийдэл хайдаг болсон нь хамгийн үнэ цэнтэй өөрчлөлт байсан. Ялангуяа суралцагчид маань сурсан зүйлээ ажлын байран дээрээ шууд хэрэгжүүлж, туршлагаа хоорондоо хуваалцаж байгааг хараад цаашид ч төслийн удирдлагын мэдлэгийг илүү энгийн, хүртээмжтэй байдлаар түгээх хүсэлтэй болсон. Тэр хүсэлдээ хөтлөгдөөд одоо “Birkbeck University of London”-д Бизнес шинжилгээ чиглэлийн судлаач оюутнаар суралцаж байна.



Б.Сувдаа

“IT Support” ангийн
2024 оны үндсэн багш

2024 онд “Grow with Google Mongolia” хөтөлбөрт багшлах хугацаандаа IT support хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн ойлголтуудыг аль болох суурь шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбарлаж, суралцагчид хэрэгцээтэй бол хэзээ ч хамаагүй асууж лавлах боломжийг нь олгохоос гадна бусад мэргэжлийн багш нарыг зочин илтгэгчээр урьж илүү бодит туршлага олгохыг зорьж ажилласан. “IT support” бол дэлхийн хэмжээний сургалтын хөтөлбөр бөгөөд жил ирэх тусам зах зээлийн шаардлага нэмэгдэж заавал эзэмших ур чадваруудын нэг болсоор байна.





“Data Analytics” болон “Advanced Data Analytics” хөтөлбөрөөр дамжуулан суралцагчдад өгөгдлийг цуглуулах, боловсруулах, шинжлэхээс эхлээд үр дүнгээ тайлагнах хүртэлх бүтэн процессыг практикт тулгуурлан эзэмшүүлэхийг зорьсон. Сургалтын төгсгөлд суралцагчид SQL, Tableau зэрэг хэрэгслүүдийг ашиглан өгөгдөлтэй бие даан ажиллаж, утга учиртай дүгнэлт гаргах чадвартай болсон. Хамгийн чухал нь тэдний аналитик сэтгэлгээ, асуудалд хандах арга барил мэдэгдэхүйц сайжирсан гэж харж байна. Олон салбарын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтын ач холбогдлыг түгээх нь миний хувьд ч үнэ цэнтэй туршлага байсан.

Б.Дуламсүрэн

“Data analytics” ангийн
2026 оны туслах багш



“Data Analytics” болон “Advanced Data Analytics” хөтөлбөрт туслах багшаар ажиллахдаа суралцагчдыг бодит жишээ, дасгал ажилд тулгуурлан суралцах орчин бүрдүүлэхийг зорьсон. Сургалтын эхэнд дата аналитикийг төвөгтэй гэж хардаг байсан олон хүн төгсөхдөө өгөгдөлд суурилан асуулт тавьж, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах чадвартай болсон нь хамгийн том өөрчлөлт байлаа. Энэ хөтөлбөр нь залуусын аналитик сэтгэлгээг хөгжүүлж, хөдөлмөрийн зах зээл дэх өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлж байна гэж боддог. Ялангуяа эхэндээ өөртөө итгэлгүй байсан суралцагчид өөрсдийн анализын үр дүнг тайлбарлаж чаддаг болсон нь надад хамгийн их урам өгсөн.

Б.Нямсүвд

“Data analytics” ангийн
2026 оны туслах багш



Бид хөтөлбөрийн суралцагчдад хиймэл оюуныг ажил, амьдралдаа хэрхэн зөв ашиглаж, бүтээмжээ өсгөх сэтгэлгээг суулгахыг зорьсон. Сургалтын явцад суралцагчид хиймэл оюуны шинэ боломжуудыг нээж, сурсан зүйлээ шууд ажил, бизнестээ ашиглаж эхэлж байгааг харах маш сайхан байлаа. Зарим суралцагч хиймэл оюун ашиглан хувийн бизнесээ өргөжүүлж, бүр өөрсдөө код бичин бүтээгдэхүүн хөгжүүлж байсан бол зарим нь санаагаа илүү бодит болгож чадсан. Миний хувьд ч энэ туршлага хиймэл оюуны боломжуудыг шинээр нээсэн, өөр өнцгөөс харах боломж олгосон шинэ эхлэл болсон.

Б.Ану-Үжин

“AI for Business”, “AI
Essentials” ангийн 2026
оны туслах багш



Манай ангид 19 настай залуугаас эхлээд 55 настай, тэтгэвэртээ гарахаар бэлдэж буй суралцагч гээд нас насны, маш олон салбарын хүмүүс нэг дор цугласан нь маш онцлог байлаа. Миний гол үүрэг тэднийг нэг анги болгон нэгтгэж, анги зохион байгуулалт болон хөтөлбөрийн оролцоог дэмжихэд түлхүү анхаарсан. Мөн салбар бүрийн туршлагатай төслийн менежерүүдийг урьж, онолыг бодит туршлагатай холбосноор суралцагчдад төслийн удирдлага бол өдөр тутмын ажил, амьдралтай салшгүй холбоотой ур чадвар гэдэг ойлголтыг өгсөн. Суралцагчид хөтөлбөрийн явцад шинэ мэдлэг эзэмшээд зогсохгүй “Би хэн бэ, би цаашид хэрхэн хөгжих вэ” гэдэг асуултыг өөрөөсөө асууж, карьерын дараагийн алхмаа тодорхойлж чадсан гэж итгэж байна.

Б.Номинзул

“Project Management”
ангийн 2026 оны туслах
багш



Хөтөлбөрийн эхэнд хиймэл оюуныг технологийн салбарын, өндөр техник ур чадвартай хүмүүсийн ашигладаг зүйл гэж хардаг суралцагч олон байсан. Харин сургалтын төгсгөлд тэд хиймэл оюуныг өдөр тутмын ажил, амьдралдаа ашиглаж, “ийм энгийн зүйл байсан юм уу” гэх ойлголттой болж, өөрсдөө туршиж хэрэгжүүлэх идэвхтэй болсон нь хамгийн том өөрчлөлт байлаа. Өөр өөр хүмүүст хиймэл оюуныг заах нь миний хувьд маш сонирхолтой бөгөөд өгөөжтэй туршлага байсан. Суралцагчдад сурсан зүйлээ ажил, амьдралдаа ашиглаж байгааг харах, заримдаа зөвлөх үедээ би өөрөө шинэ мэдлэг ур чадварт давхар суралцаж байгаагаа мэдрэх таатай байлаа.

Э.Лхагвасүрэн

“AI Essential, AI for
Business” ангийн 2026
оны туслах багш



Миний зорилго бол кибер аюулгүй байдлын онолын ойлголтыг бодит жишээ, практик дасгал болон тоглоомчилсон сургалтын аргуудтай хослуулж, суралцагчдыг идэвхтэй оролцох орчин бүрдүүлэхэд чиглэсэн юм. Суралцагчдын өмнөх мэдлэг, туршлага харилцан адилгүй байсан нь тодорхой хэмжээний сорилт болж байсан. Гэхдээ өөр салбарт ажилладаг ч гэсэн кибер аюулгүй байдлыг чин сэтгэлээсээ судалж суралцаж байгаа суралцагчдаараа маш их бахархсан. Энэ хөтөлбөрөөр дамжуулан залуус цаашид кибер аюулгүй байдлын чиглэлийг илүү сонирхон судалж, тус салбарт өөрсдийн боломж, карьераа тодорхойлсон гэдэгт итгэлтэй байна.

Ц.Ганболд

“Cybersecurity” ангийн
2026 оны туслах багш



Хөтөлбөрийн явцад суралцагчдын хоорондын харилцаа, хамтын ажиллагаа буюу багаар ажиллах чадвар маш сайн байсан. Мөн суралцагчид анхны өдөртэй харьцуулахад мэдээллийн аюулгүй байдлын үндсэн ойлголтуудыг сайн ойлгож, цаашид өөрсдийн сонирхон судлах, гүнзгийрүүлэх чиглэлээ тодорхойлж чадсан юм. Миний хувьд ч энэхүү хөтөлбөр шинэлэг, өөрийгөө сорьсон үнэ цэнтэй туршлага болон үлдлээ. Өөр өөрсдийн онцлог, ялгаатай хүмүүст хичээл заахын тулд багш хүн өөрөө өргөн мэдлэгтэй байхаас гадна суралцагчтай хэрхэн зөв харилцах, ажиллах зэрэг олон талын ур чадвар шаарддаг гэдгийг ойлголоо.

У.Анхбаяр

“Cybersecutiry” ангийн
2026 оны туслах багш



Хиймэл оюуныг хэрэглээ болгож сурах нь өнөөдөр дэлхий дахинд залуусын өрсөлдөх чадварын суурь үзүүлэлт болоод байна. Үүнийг дотоодын зах зээлд цаг алдалгүй нутагшуулахад Gemini платформ болон Workspace-ийн экосистем маш чухал үүрэг гүйцэтгэж байна. Суралцагчид маань ч үүнийг ашиглаж өөрсдийн ажлын тодорхой хэсгүүдийг автоматжуулж, бүтээмжээ нэмэгдүүлж чадсан нь сайшаалтай байлаа. Энэхүү хөтөлбөр Монголын залуучуудыг зөвхөн хэрэглэгч гэхээс илүү хиймэл оюун ашиглан үнэ цэн, шинэ боломжуудыг бүтээгч, олон улсад өрсөлдөх чадвартай дижитал мэргэжилтнүүд болоход бодит хөрөнгө оруулалт болж байгаа гэдэгт итгэлтэй байна.

Э.Энхбаяр

“AI Essential, AI for
Business” ангийн 2026
оны туслах багш



Өнгөрсөн жил ЦойлогсоZ багаасаа хөтөлбөрийн зохион байгуулагчаар ажиллаж байсан бол энэ жил багшийн хувиар суралцагч бүрийн карьерт бодит үр нөлөө үзүүлэхийг зорилоо. Ангид маань инженер, эдийн засагч, сэтгүүлч гээд олон төрлийн мэргэжилтнүүд цугласан байсан бөгөөд тэдэнд маркетинг бол сурталчилгаа биш, харин асуудлыг бүтээлчээр шийдэж, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөх замаар үнэ цэн бүтээдэг салбар гэдгийг ойлгуулахыг зорьсон. Үүний тулд олон улсын шилдэг кэйсүүдийн ард өрнөдөг процесс, бүтээлч санааны эрэлхийллийг тайлбарлаж, Монголдоо болон өөрсдийн бизнест хэрхэн хөрвүүлэн ашиглах арга зүйг заасан. Хөтөлбөрийн төгсгөлд суралцагчид маань маш олон шинэлэг санааг гаргаж, ажил, амьдралдаа бодитоор хэрэгжүүлж эхэлснийг сонсох хамгийн сайхан мөч байсан шүү.

Э.Мөнхжаргал

“Digital marketing & E-
Commerce” ангийн 2026
оны туслах багш



Техник, технологи асар хурдтай хувьсан өөрчлөгдөж буй эрин зуунд амьдарч байгаагийн хувьд бидэнд тэр хурдтай хөл нийлүүлэн алхдаггүй юм гэхэд хоцрохгүй явах сорилт тулгарч байна. Тиймээс бид суурь мэдлэгээ дээшлүүлж, зөөлөн ур чадвараа анхнаас нь зөв хөгжүүлэх хэрэгтэй. Тиймээс зөвхөн хичээл заахаас илүү ажлын байран дээрээ олж авсан өөрийн бодит туршлагаас суралцагчидтайгаа хуваалцахыг хичээсэн. Анх хичээл эхлэхэд ихэнх нь "би үнэхээр чадах болов уу" гэсэн айдастай байсан. Би ч гэсэн анх тэгж л эхэлж байлаа. Тийм учраас өөрийн арга барил, сурч мэдсэнийг хуваалцахдаа "мэдэхгүй байна гэдэг асуудал биш, харин ч өсөж хөгжих эхлэл юм шүү" гэдгийг бусдад ойлгуулахыг хүссэн.

Г.Мөнхдэлгэр

"IT Automation with Python" ангийн 2026 оны туслах багш



Миний хувьд суралцагчидтайгаа жинхэнэ найз нь болох зарчмаар ажиллахыг зорьсон. Мэдэхгүй зүйлээ асуухдаа ичих, санаа зовох шаардлагагүй гэдгийг мэдрүүлэхийг хичээж, хамт олны уур амьсгалыг сайжруулахаас гадна өөртөө итгэлтэй, хичээлдээ идэвхтэй оролцоход нь түлхүү анхаарч ажилласан. Суралцагчид өдөр тутмын амьдралдаа тулгарч буй асуудлыг дизайнерын нүдээр харж, шүүмжлэлт сэтгэлгээ нь ч сайжирсан ажиглагдсан. Тиймээс бидний хичээл суралцагчдад техникийн ур чадвараас гадна асуудал шийдвэрлэх чадварыг олгосон юм. Энэ нь аль ч салбарт өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх суурь болно гэж харж байна.

Б.Цэцэн

"UX Design" ангийн 2026 оны туслах багш



Google-ийн сургалтын агуулга олон улсын зах зээл дээр суурилсан байдаг учраас манай улсын нөхцөлд хэрхэн хэрэгжиж, ашиглаж болох вэ гэдэг талаас нь хичээлийн хөтөлбөрөө тайлбарлах гэж хичээсэн. Тодруулбал, Монголын зах зээлийн хүрээ, Фэйсбүүкийн нөлөө хэрэглэгчдийн шийдвэр гаргалт, жижиг дунд бизнесүүдийн маркетингийн онцлог зэрэг зүйлсийг хичээлтэй холбож тайлбарлаж, маркетинг бол зөвхөн контент хийх эсвэл пост оруулдаг ажил биш, харин бизнесийн зорилгоо биелүүлэхэд ашигладаг хэрэгсэл болохыг системтэй хүргэхийг зорьсон.

Э.Анар

"Digital Marketing & E-commerce" ангийн 2024-2025 оны туслах багш



Кибер аюулгүй байдлын салбар нь маш өргөн цар хүрээтэй учраас анхнаасаа суурь ойлголтоо зөв тавьж чадвал цаашид аль ч чиглэлээр хөгжих боломжтой бөгөөд өөрийн сонирхол, зорилгоо ч оновчтой тодорхойлох боломжтой. Энэхүү хөтөлбөр нь олон хүний мэдлэг, ур чадварыг хөгжүүлэхээс гадна өөрийгөө шинээр нээх, ирээдүйн карьерын чиглэлээ тодорхойлох боломжийг олгож байгаа нь хамгийн том давуу тал гэж боддог. Цаашид улам олон залуус, мэргэжилтнүүдийг хамруулж, практик ур чадвар болон салбарын мэргэжилтнүүдтэй холбогдох боломжийг өргөжүүлэн хөгжүүлээсэй гэж хүсэж байна.

Т.Нямжаргал

"Cybersecurity" ангийн
2025 оны туслах багш



Манай мэргэжлийн хувьд технологид суурилсан, хурдацтай хөгжиж буй салбар учраас туштай суралцаж чадвал хөдөлмөрийн зах зээлд өндрөөр үнэлэгдэх боломжтой гэж хардаг. Миний хувьд ч энэ хөтөлбөр цаг үетэйгээ хөл нийлүүлэн хөгжих, суралцагчид болон зочин илтгэгчдээс суралцах, шинэ хамт олонтой болох үнэ цэнтэй туршлага байлаа. Хөтөлбөрийн явцад суралцагчид машин сургалтын арга, өгөгдөлтэй ажиллах ур чадваруудыг бодит төслүүд дээр туршин суралцсан нь мэдлэгээс гадна өөртөө итгэх итгэлийг нь мэдэгдэхүйц нэмэгдүүлсэн гэж харж байна.

М.Төгөлдөр

"Data Analytics" ангийн
2025 оны туслах багш



Сургалтын эхэнд суралцагчид өгөгдлийг ихэвчлэн Excel-ийн түвшинд л ойлгодог байсан бол хичээлийн төгсгөлд өгөгдлөөр асуудал тодорхойлох, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргалтад ашиглах сэтгэлгээ нь илүү хөгжсөн гэж харж байна. Мөн дата цэвэрлэх, дүрслэх, тайлагнах болон өгөгдлөөр түүх өгүүлэх чадвар бодитоор сайжирсан. Өнөөдөр өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт нь бизнес, маркетинг, технологи зэрэг бүх салбарт чухал байр суурь эзлэх болсон. Тиймээс "Grow with Google Mongolia"-гийн Data Analytics хөтөлбөр нь суралцагчдад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэхээс гадна хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь маш том дэмжлэг болж байна.

Б.Баялагмаа

"Data Analytics" ангийн
2024 оны туслах багш



Хичээлийн хүрээнд бодит практик жишээнүүдийг ашиглахыг зорьсон бөгөөд суралцагчид ч үнэхээр сонирхож хүлээж авч байлаа. Жишээлбэл, суралцагчид маань Wi-Fi router ямар протоколоор, хэрхэн ажилладаг, сүлжээ нь хэр аюулгүй эсэхийг бие даан шалгаж сурахдаа хамгийн их идэвхтэй, хичээл зүтгэлтэй байв. Энэхүү Google-ийн мэргэжлийн гэрчилгээ олгох хөтөлбөр нь Монголын хөдөлмөрийн зах зээлд хөл тавьж буй залууст маш том боломжийг олгож байна. Залуус маань цаашид тасралтгүй суралцаж, ур чадвараа хөгжүүлсээр байвал дотоодын төдийгүй олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай мэргэжилтнүүд болох боломж бий. Тиймээс оролцогчдоо технологийн хурдтай хөл нийлүүлэн, шинэ зүйлийг туршихаас хэзээ ч бүү эмээгээрэй гэж зөвлөх байна.

Б.Амарболд

"IT Support" ангийн 2024
оны туслах багш









Төслийн санаачлагч баг: Тасралтгүй суралцах дадал, боловсролын шинэ соёл түгээхийг зорьж байна

Олон улсын стандарт, арга зүйг дотоодын хөрсөнд нутагшуулах, төслийн зохион байгуулалтыг тогтвортой авч явах нь нарийн төлөвлөлт болон багийн тасралтгүй сайжруулалтыг шаарддаг үйл явц юм. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад өрнөсөн менежментийн үйл ажиллагаа, жил бүрийн зохион байгуулалтын ахиц дэвшил болон цаашдын зорилго чиглэлийн талаар тус хөтөлбөрийн санаачлагч болон зохион байгуулагч "Go Lab" багийнхантай ярилцлаа.

Олон улсын хөтөлбөрийг Монголын хөрсөнд буулгах анхны алхам ямар сорилтуудтай тулгарсан бол?



Б.Тэмүүлэн: Google зэрэг олон улсын томоохон байгууллагатай хамтран ажиллахад нарийн, урт хугацааны бэлтгэл ажил өрнөдөг. Бид Google талд хөтөлбөрийн зорилго, хамрах хүрээ, оролцогчдын бүтэц, хэрэгжилтийн төлөвлөгөө, хүлээгдэж буй үр дүнгээ тодорхой танилцуулж, тэтгэлэг, хөтөлбөрийн эрхийг авахын тулд олон шатны зөвшилцөл, баталгаажуулалтын процессыг давсан.

Энэ явцад хамгийн сонирхолтой бөгөөд хамгийн чухал сорилт нь хоёр өөр орчныг хооронд нь ойлголцуулах байсан. Нэг талд олон улсын байгууллагын өндөр стандарт, чанарын шаардлага, үр дүнгийн хүлээлт бий. Нөгөө талд Монголын оролцогчдын бодит нөхцөл, хэлний бэрхшээл, цагийн хуваарь, ажлын ачаалал, орон нутгийн хүртээмж, суралцах дадлын ялгаа бий. Бид энэ хоёрын дунд гүүр болж ажилласан. Өөрөөр хэлбэл, олон улсын арга зүйг Монголын бодит амьдралд ойртуулахын зэрэгцээ Монгол оролцогчдыг олон улсын шалгуур, хариуцлага, суралцах сахилга баттай холбохыг зорьсон.



Б.Номинзул Миний хувьд энэ хөтөлбөрийг зөвхөн сургалт гэж харахаас илүү хүний нөөцийн том ундарга гэж хардаг. Google-ийн экосистем өөрөө дэлхийн хэмжээний асар том мэдлэг, инновац, технологийн сүлжээ. Түүнийг Монголд нутагшуулах явцад зөвхөн суралцагчид хөгжөөд зогсохгүй зохион байгуулагч баг, багш нар, менторууд, хамтрагч байгууллагууд бүгд хамтдаа өсөж хөгжиж байна.

Хөтөлбөрийг зорин ирж буй хүмүүсийг ажиглахад тэд амьдралын ямар үе шат, зорилго дээрээ голцуу ирж байна вэ?



Э.Өсөхбаяр: Манай хөтөлбөрт хамрагдаж буй хүмүүсийг ажиглахад дөрвөн үндсэн бүлэг тод харагддаг. Нэгдүгээрт, карьераа ахиулах, одоогийн ажилдаа илүү үнэ цэнтэй болохыг хүсэж буй хүмүүс. Тэд шинэ ур чадвар эзэмшиж, байгууллага дотроо албан тушаал ахих, илүү өндөр түвшний ажилд шилжих зорилготой ирдэг. Зарим байгууллага Google-ийн сертификатыг хүний нөөцийн хөгжлийн системтэйгээ холбож, албан тушаал ахих нэг шалгуур болгон ашиглаж эхэлсэн нь олон улсын сертификат хувь хүний CV-ээс гадна байгууллагын ур чадварын бодлогод ч бодит үнэ цэнтэй болохыг харуулж байна.

Хоёрдугаарт, бизнесээ эхлүүлэх эсвэл өсгөхийг зорьж буй хүмүүс. Дижитал маркетинг, контент, борлуулалтын суваг, хэрэглэгчээ ойлгох арга барилыг сурч, хумсны салон, хивс экспорт, хөшигний бизнес зэрэг бодит кэйсүүд дээр шууд хэрэгжүүлж байна.

Гуравдугаарт, салбараа өөрчлөх, гадаадад суралцах, олон улсын хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх зорилготой хүмүүс. Эмч, судлаач, инженер, багш зэрэг өөр өөр мэргэжлийн хүмүүс технологи, өгөгдөл, хиймэл оюун, UX/UI зэрэг шинэ чиглэл рүү хөрвөх сууриа тавьж байна.

Дөрөвдүгээрт, төрсний дараа ажил, нийгмийн амьдралдаа эргэн орохыг хүссэн ээжүүд. Тэдний хувьд энэ нь зөвхөн сургалт биш, өөртөө итгэх итгэлээ сэргээж, шинэ ур чадвар эзэмшиж, идэвхтэй орчинд дахин холбогдох боломж болж байна.

Хөтөлбөрийн хамгийн үнэ цэнтэй, дурсамжтай мөчүүдээс хуваалцвал?



Б.Энхмөрөн: Хөтөлбөрийн хамгийн үнэ цэнтэй хэсгүүдийн нэг нь “Grow with Google Challenge” буюу бодит төсөл хөгжүүлэх тэмцээн байдаг. Оролцогчид өөр өөр мэргэжил, өөр өөр ангиас баг болон нийлж, бодит асуудал шийдэх төсөл боловсруулдаг. Энэ нь зөвхөн слайд бэлдээд илтгэх төдий биш, харин санаагаа бүтээгдэхүүн, үйлчилгээ, прототип, бизнесийн шийдэл болгон турших боломж юм. Зарим нь хог дахин ялгадаг ухаалаг хогийн сав хийж үзүүлсэн. Зарим төсөл өнөөдөр бие даасан бизнес болж, хөгжсөн байгаа нь хөтөлбөрийн бодит үр дүнг харуулж байна.

Мөн анхны элсэлтийн оролцогч Мишээлийн түүх бидэнд маш их урам өгсөн. Тэр хөгжлийн бэрхшээлтэй хэдий ч UX дизайны чиглэлээр идэвхтэй суралцаж, аавынхаа дэмжлэгтэйгээр хөтөлбөрт туштай оролцсон. “Grow with Google Challenge”-ийн үеэр багийнхантайгаа хамтран аппликэйшний дизайн дээр ажиллаж, өөрийн санаа, шийдлийг компьютер дээр маш чадварлаг гаргаж чадсан. Энэ түүх бидэнд хүртээмжтэй боловсрол ямар их боломж нээж чаддагийг дахин сануулсан.

Бид мөн оролцогчдын хүрээллийг тэлэх зорилгоор уулын алхалт зохион байгуулсан. Тэнд 17, 18 настай залуус 50, 60 настай оролцогчидтой хамт алхаж, ярилцаж, суралцсан. Тэтгэвэртээ гарсны дараа карьераа бүрэн өөрчилж, төслийн удирдлагын чиглэлээр ажиллах зорилготой оролцогч бусад залуустаа маш их урам өгсөн. Тэр хүн бидэнд “хүн биеэрээ хөшиж өтөлж болох ч тархи бол тасралтгүй ажиллаж, хөгжиж байх ёстой залуу эрхтэн” гэдгийг харуулсан.



Б.Тэмүүлэн: Богд ууланд хөтөлбөрөөрөө алхаж байхдаа анх кофе зардаг хоёр залуутай танилцаж, хөтөлбөрөө сонирхуулж байсан юм. Дараагийн элсэлтээр тэд дижитал маркетингийн ангид орж, суралцах хугацаанд нь анги хамт олон нь тэр хоёр залуугийн бизнесийг дэмжих социал кампанит ажил өрнүүлсэн. Үүний үр дүнд бизнес нь өргөжин одоо кэйтеринг үйл ажиллагаа эрхэлдэг, хотын төвд өөрсдийн поп-ап кофе шоптой бизнес болж өөрчлөгдсөн.

Бид хөтөлбөрийн хүрээнд төслийн удирдлага, дата аналитикс, дижитал маркетинг зэрэг 8-9 өөр чиглэлийн ангиудыг хооронд нь хольж, хамтрах боломжийг чухалчилсан. Энэхүү багуудын холимог бүтэц нь шинэ стартап, шинэ бизнесүүд шууд төрөн гарах бодит хөрс суурийг бүрдүүлж, шууд үр дүнгээ өгч байгаа юм.

Энэхүү хөтөлбөр уламжлалт боловсролын системээс юугаараа ялгарч байна вэ. Цаашид Монголын боловсролын салбарт ямар шинэ соёл, алсын харааг үлдээхийг зорьж байна вэ?



Э.Өсөхбаяр: Энэ жилийн хөтөлбөрийн нэг гол онцлог бол бид хиймэл оюуны эрин үетэй салшгүй холбогдсон явдал.

Дэлхий даяар хиймэл оюун маш гүн гүнзгий нэвтэрч байгаа учраас бид ч гэсэн хөл алдахгүй, хоцрохгүй байхыг хичээж, үндсэн зургаан ангийнхаа агуулгыг бүхэлд нь шинэчилж, хиймэл оюуныг процесс дундаа яаж ашиглах вэ гэдэгт чиглүүлсэн. Google корпорацын хувьд ч энэ жилийн гол зорилго нь Gemini хэрэглэгчийн тоог нэмэх, технологийн зохицол, шилжилтийг эрчимжүүлэхэд чиглэж байгаа учраас бид энэ хэмнэлтэй хамт урагшилж байна.

Хөтөлбөрийн бас нэгэн суурь бол боловсролын систем дэх суралцах процессыг өөрчилж байгаа явдал юм. Өмнө нь манай боловсролын систем ерөнхийдөө шалгалт дээр суурилж, суралцагчдад заавал дүн тавьж, заримыг нь унагах гэж шалгалтыг зориуд хүнд авдаг буюу өөрөөр хэлбэл, суралцахыг нь хэмжих биш, зүгээр л хүмүүсийг тестээр ялгах гэж оролддог байсан. Харин “Grow with Google Mongolia” хөтөлбөрийн гаргаж ирж буй шинэ санаа бол “Just-in-Time Learning” буюу яг хэрэгцээт цагт нь сургах загвар юм. Энэ нь хүнд яг одоо ямар нэгэн зүйл хийх шаардлага тулгарахад хэрэгтэй ур чадвараа хиймэл оюуны тусламжтайгаар маш хурдтайгаар шууд авах боломж шүү дээ. Заавал тусдаа цаг гаргаж, зовж сурах биш, шинэ содон зүйлстэй хөл нийлүүлэн алхдаг, өглөөний цайгаа уудаг шиг суралцах гэдэг зүйлийг амьдралынхаа өдөр тутмын хэв маяг, соёл болгоосой гэж хүсдэг.



Б.Номинзул: Боловсролын салбарт бидний нэвтрүүлэхийг зорьсон нэг чухал өөрчлөлт бол “багш” гэдэг ойлголтыг илүү өргөнөөр харах явдал. Багш гэдэг заавал багшлах мэргэжлээр төгссөн хүн байх албагүй. Зарим тохиолдолд тухайн салбартаа бодит туршлага хуримтлуулсан, асуудлыг өдөр бүр шийдэж байгаа, зах зээлийн хэрэгцээг биеэрээ мэдэрч буй практик мэргэжилтэн хамгийн үнэ цэнтэй багш болж чаддаг.

Бид хөтөлбөрийн хүрээнд салбартаа ажиллаж буй мэргэжилтнүүдийг багшаар урьж, тэднийг хөтөлбөрийн арга зүй, агуулга, сургалтын төлөвлөгөөгөөр бэлтгэж, оролцогчидтой ажиллуулсан. Энэ нь их, дээд сургуулийн онолд төвлөрсөн загварыг үгүйсгэж байгаа хэрэг биш. Харин түүнийг хөдөлмөрийн зах зээлийн бодит туршлага, практик кэйс, олон улсын аттестатчилагдсан ур чадвартай холбож байгаа хэрэг юм.



Г.Тэмүгэ: Манай боловсролын салбарт онол, практикийн зааг хэт хол байх тохиолдол олон. Оюутнууд мэдлэгтэй төгсдөг ч ажлын байранд хэрэгтэй ур чадвар, асуудал шийдэх туршлага дутмаг байх нь бий. “Grow with Google Mongolia” энэ зөрүүг багасгах нэг загвар болж чадна гэж бид харж байна. Оролцогчид зөвхөн лекц сонсох биш, баг болж ажиллах, бодит кэйс шийдэх, бизнес, байгууллага, нийгмийн асуудал дээр турших, “Grow with Google Challenge”-ээр дамжуулан санаагаа хэрэгжүүлэх боломжтой байсан нь хөтөлбөрийн хамгийн чухал ялгарал юм.

Ирээдүйд энэ хөтөлбөрөөс зөвхөн ур чадвартай төгсөгчдөөс гадна технологиор хүч нэмсэн, сайн бүтээгдэхүүнтэй, олон улсын зах зээлд гарах потенциалтай монгол компаниуд төрөн гараасай гэж хүсдэг. Тэд Монголын шинэ үеийн шилдэг аж ахуйн нэгжүүд, экспортлогчид, ажлын байр бүтээгчид болж, эдийн засгийн төрөлжилт, бүтээмж, инновацад бодит хувь нэмэр оруулах нь бидний алсын хараа юм.

“Grow with Google Mongolia” бидэнд боловсрол бол ганц мэдлэг дамжуулах үйл явц биш гэдгийг нотолсон. Боловсрол бол хүнийг шинэ боломжтой холбох, өөртөө итгэх итгэлийг нь сэргээх, бодит асуудал шийдэх чадвартай болгох, хамтдаа хөгжих орчныг бий болгох үйл явц гэдгийг энэхүү хөтөлбөрөөсөө бататгаж авсан.



**1,125
ТӨГСӨГЧ**

Хөтөлбөрийн хүрээнд нийт 1,125 суралцагч сургалтаа амжилттай төгсөж, олон улсын сертификаттай болоод байна.



**46,000 цагийн
ОНЛАЙН ХИЧЭЭЛ**

Оролцогчид нийтдээ 46,000 гаруй цагийн онлайн сургалтад хамрагдаж, тасралтгүй суралцсан идэвх чармайлтыг харууллаа. Хөтөлбөрийн хугацаанд олон улсын түвшний мэргэжлийн агуулгыг бие даан судалж, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн юм.

**9 төрлийн
сургалт**

Хөтөлбөрийн хүрээнд ажлын байранд хамгийн эрэлттэй 9 мэргэжлийн чиглэлээр сургалт зохион байгуулагдсан бөгөөд ахисан түвшинд суралцагчид банк санхүүгийн өгөгдөл шинжилгээ, барилгын салбарын төслийн удирдлага гэх мэт нарийн мэргэжлийн чиглэл сонгож, гүнзгийрүүлэн судлав.



ЦойлогсоZ:

Хамтдаа нөлөөлж, хамтдаа цойлцгооё!



“Grow with Google Mongolia” хөтөлбөрийг ЦойлогсоZ залуусын комьюнити “Go Lab” ХХК-тай хамтран хоёр дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна. Гурван жилийн хугацаанд 1,125 залууст дижитал ур чадвараа хөгжүүлж, бүтээмжээ нэмэгдүүлэх боломжийг нээсэн энэхүү хөтөлбөрт ЦойлогсоZ багийн гишүүд хэрхэн хамтарч ажилласан туршлага, өөрт болон суралцагчдад гарсан бодит өөрчлөлт мөн тус хөтөлбөрийн ач холбогдлыг хэрхэн харж буй талаараа хуваалцлаа.

ЦойлогсоZ залуусын комьюнити болон “Grow with Google Mongolia” хөтөлбөрийн хамтын ажиллагаа анх хэрхэн эхэлж байв?



Б.Батзориг: Бидний хамтын ажиллагаа 2024 онд зохион байгуулсан комьюнити эвентээс эхлэлтэй. Манай багийн гол зорилгуудын нэг залуучуудын дижитал ур чадварыг нэмэгдүүлж, хөдөлмөрийн зах зээлд хамгийн эрэлттэй ур чадваруудыг хүртээмжтэй хүргэх явдал юм. Энэхүү зорилготой маань “Grow with Google Mongolia” хөтөлбөрийн зорилго ч нийцэж байлаа. Ийнхүү бид уг төсөлд анх хамтын ажиллагааны түнш байгууллагаар оролцож байсан бол энэ жил маркетинг, үйл ажиллагаа, гүйцэтгэл зэрэг илүү өргөн хүрээнд оролцож хамтран зохион байгуулагчаар ажиллалаа. Уг хөтөлбөрийн онцлог нь ганц байгууллага эсвэл нэг багш дээр төвлөрдөггүй, харин салбар салбарын мэргэжилтнүүд, байгууллагуудын хамтын ажиллагаа, комьюнитид суурилсан арга барилаар үнэ цэн бүтээдэгт оршиж байгаа.

Та “Grow with Google Mongolia” хөтөлбөр Монголын залуучуудад бодитоор хүрч чадсан гэж боддог уу. Цаашдын зорилгоосоо бидэнтэй хуваалцаач?

“Grow with Google Mongolia” хөтөлбөр монгол залуучуудын ур чадвар, мэдлэгт бодит нөлөө үзүүлж чадсан гэж үзэж байна. Учир нь бид олон улсын хэмжээний агуулгыг дотоодын практиктай хослуулж, залуучуудад зөвхөн мэдлэг олгоод зогсохгүй, бодит амьдрал дээр буюу ажлын байран дээр шууд ашиглах боломжтой ур чадварыг ч давхар олгосон. Техник технологийн хөгжил хурдацтай явагдаж байгаа энэ цаг үед бид дэлхийн хөгжлөөс хоцрох ёсгүй. Тиймээс бид цаашид илүү хүртээмжтэй, үнэ цэнтэй боловсролын боломжийг бий болгож залуучуудын бүтээмж, дижитал ур чадвар, хамтын ажиллагааг дэмжих төслүүдэд идэвхтэй оролцдог, зохион байгуулдаг байр сууриа хадгалсаар байх болно.

“Grow with Google Mongolia” хөтөлбөрт багшилж, залуучуудтай ойроос ажиллах ямар байсан бэ. Хичээлийн хөтөлбөрөө боловсруулахдаа юун дээр түлхүү анхаарав?



Э.Мөнжаргал: “Grow with Google Mongolia” 2025 оны хөтөлбөр залуус руу чиглэснээр суралцагчдын нас, мэргэжлийн хүрээ харьцангуй ойролцоо байсан бол энэ жилийн хөтөлбөрт инженер, бизнес эрхлэгчээс эхлээд, зохиолч хүртэл маш олон салбарын, өөр өөр насны хүмүүс нэг ангид цугласнаараа онцлог байлаа. Эхэндээ “хичээлийн агуулга бүх хүнд ойлгомжтойгоор хүрч чадах болов уу” гэж эргэлзэж байсан ч Google-ийн олон улсад батлагдсан сургалтын агуулга, Coursera дээрх хөтөлбөрийг гол сууриа болгож, үүн дээрээ нэмэлт практик

хэрэглээ, олон улсын бодит жишээн дээр төвлөрснөөр олон талт мэдлэгийг цэгцтэйгээр өгөх боломж бүрдсэн. Суралцагчид маань ч сурсан зүйлээ өөрийн ажил, бизнест шууд ашиглах боломжийг бүрдүүлэхийг зорин ажилласан.

Таны хувьд “Grow with Google Mongolia” хөтөлбөрийн хамгийн үнэ цэнтэй үр дүн юу байсан бэ. Суралцагчид болон өөрт тань гарсан өөрчлөлтөөс хуваалцаач.

Нэг суралцагч хичээл дээр үзсэн суурь загваруудаа ашиглан хэдхэн долоо хоногийн дотор 30 сая төгрөгийн дүнтэй ажил хэрэгжүүлсэн тухайгаа хуваалцсан. Өөр нэг бизнес эрхлэгч өмнө нь маркетингийн бүх ажлаа бусдад даатгадаг байсан бол одоо багтайгаа илүү хамтарч ажиллаж, борлуулалтын өсөлтөө өөрөө хянаж чаддаг болсон гэсэн юм. Мөн зохиолч мэргэжилтэй суралцагч маань “аливаа зүйлийг олон өнцгөөс харж сурлаа” гэж хэлсэн нь сэтгэлд тод үлдсэн байна. Эдгээр өөрчлөлтөөс харахад манай хөтөлбөр суралцагчдын сэтгэлгээ, шийдвэр гаргалт зэрэгт эергээр нөлөөлж хувь хүний өсөлт хөгжилд бодит үнэ цэн бий болгож буйг харж болохоор байна.

Хөтөлбөрийн бүртгэл, сонгон шалгаруулалтыг хариуцах үед танд хэцүү санагдсан үе бий юу. Тэдгээрээс та юу сурч ойлгов?



Г.Дашням: Хэцүү санагдсан үе гэхээс илүү энэхүү хөтөлбөрийн үндэслэл, зорилгод нэгдэж, хэрэгцээтэй хүмүүст нь хүргэх тал дээр түлхүү анхаарч ажилласан. Гэхдээ одоог хүртэл орон нутгийн залууст тус хөтөлбөрийг хүргэх тал дээр сорилттой хэвээр байна. Орон нутгийн залууст хэлний бэрхшээл, ур чадварын зөрүү зэрэг ялгаатай тал байгаа ч эрэлт хэрэгцээ өндөр байгаа ажиглагдсан. Тиймээс тэдэнд илүү хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд “Grow with Google” хөтөлбөрийг Монголд илүү гүнзгий хэрэгжүүлэх боломжтой гэж харж байгаа юм. Энэхүү сорилт нь хүнд хэцүү зүйл гэхээс илүү гарц, гаргалгаа, боломжуудыг хамтдаа бүтээх сэдэл болж байна.

Олон нийтийн дижитал ур чадварын талаар ойлголт, хандлага ямар түвшинд байна вэ. Өнөөдөр залуучуудын хэрэгцээ хаашаа чиглэж, тэдэнд ямар сорилт тулгарч байгаа гэж бодож байна?

Гурван жилийн хугацаанд цуглуулсан мэдээлэл, харилцаа, хүмүүсийн санал хүсэлт зэргээс харахад “хиймэл оюун”, “өгөгдөл шинжилгээ” зэрэг ур чадваруудын эрэлт хэрэгцээ жил ирэх тусам нэмэгдэж байна. Мөн залуусын сонирхол, зорилгыг анзаарч харвал бүтээлч сэтгэлгээнд шилжээд буй. Тиймээс ч “Grow with Google Mongolia” хөтөлбөрийг гол хэрэгслээ болгож, өөрсдөө боломжийг бүтээж чаддаг болж.

Мөн хөтөлбөрийн суралцагчид ур чадвар, карьер, бизнес зэрэг амьдралын чанараа нэмэгдүүлэхээс гадна танилын хүрээ, боломжуудыг эрчимтэй эрэлхийлж байгаагаас монгол залуус хэрэглэгчээс бүтээгч рүү, өрсөлдөөнөөс хамтрал руу шилжиж байгааг харах таатай байна.

“Grow with Google Mongolia” хөтөлбөрийн хамтын ажиллагааг хариуцахдаа юунд төвлөрч ажилласан бэ. Энэ хугацаанд та хэрхэн өсөж хөгжив?



Ж.Идэртүвшин: “Grow with Google Mongolia” хөтөлбөрт ажиллах хугацаанд хамгийн хэцүү санагдсан зүйл нь суралцагчдын хүлээлтэд хүрч, суралцагч бүрд бодит үнэ цэн хүргэх байсан. Суралцагчид тав тухтай орчинд, чанартай боловсрол эзэмшиж, сэтгэл ханамж өндөр байгаасай гэж хүссэн учраас олон зүйлийг зэрэг анхаарах шаардлагатай тулгарсан. Энэхүү туршлагаас би аливаа ажлыг эртнээс төлөвлөж, хэрэгжүүлж эхлэх хэрэгтэй юм байна гэдгийг маш сайн ойлгож авсан даа. Зарим ажлыг дараа нь амжуулна гэж хойшлуулах тусам ачаалал нэг дор төвлөрч, эрсдэл нэмэгдэх магадлалтай байдаг шүү дээ.

Дижитал орчинд түлхүү ажилладаг хүний хувьд ирээдүйд ажлын байранд ямар ур чадвар шаардлагатай болох хандлагатай байна вэ?

Хиймэл оюун олон ажлыг өөрчилнө. Гэхдээ бидний суралцах чадварыг хэзээ ч орлож чадахгүй. Ирээдүйд ажлын байранд дасан зохицох чадвар, асуудал шийдэх ур чадвар, бүтээлч сэтгэлгээ, харилцааны чадвар зэрэг зөөлөн ур чадвар нэн шаардлагатай болох байх.

Хөтөлбөрийн ард төслийн бүх үе шатыг дааж ажиллахад ямар байсан бэ. Хамгийн хэцүү эсвэл хамгийн хүч сорьсон үе нь хэзээ байв?



Б.Оюундарь: Анх би “Grow with Google Mongolia” хөтөлбөрийн эхний улиралд бүртгүүлж байсан ч тэнцээгүй юм. Харин дараагийн улиралд манай баг хөтөлбөрийн хамтран зохион байгуулагчаар орж, надад суралцагчдаар биш, арын албанд ажиллах боломж тохиосон. Энэ хугацаанд 2025 оны хөтөлбөр хамгийн сорилттой нь байсан. Хөтөлбөрийн 350 гаруй суралцагчтай тогтмол харилцаж, тэдний хэрэгцээ, шаардлагыг тодорхойлон багш нар болон багийнхандаа цаг тухайд нь мэдээллийг хүргэж ажиллах нь эхэндээ хэцүү байсан ч тэр үед би бусадтай харилцах, асуудал шийдвэрлэх, багийн уялдаа холбоог удирдах зэрэг чухал ур чадварт суралцсан гэж боддог юм.

Залуучуудтай тулж ажиллах таны төсөөлж байснаас хэр өөр байсан бэ?

Хөтөлбөрийн залуус бүгд их нээлттэй. Гэхдээ сонирхолтой санагдсан зүйл нь чиглэл бүрээсээ шалтгаалаад хоорондоо их ялгаатай байдаг юм билээ. Жишээлбэл, дижитал маркетингийн ангийнхан илүү яриасаг бол IT-гийн ангийнхан их чимээгүй, төслийн удирдлагын ангийнхан илүү зохион байгуулалт сайтай байдаг гэх мэт ихэвчлэн комьюнити үйл ажиллагаанд хэрхэн оролцож байгаагаас нь онцлог ялгаа их ажиглагдсан.

Та “Grow with Google Mongolia” хөтөлбөрт ажиллахдаа юунд хамгийн их анхаарсан бэ?



М.Номин: Бид бүгд “Grow with Google Mongolia” хөтөлбөрийг үр дүнтэй, өгөөжтэй, суралцагчдад бодит үнэ цэн өгөх байдлаар амжилттай дуусгах хамтын зорилготой байсан. Тиймээс хамтран ажиллах явцад харилцан ойлголцол, уялдаа холбоо, мэдээллийн нэгдмэл байдалд түлхүү анхаарсан. Бүх ажлын цаана суралцагчдын итгэл, хүлээлт байгаа учраас жижиг гэлтгүй бүх зүйлд хариуцлагатай, нягт нямбай хандахыг хичээсэн дээ.

Хөтөлбөрийн үеэр таны бахархлыг төрүүлж, сэтгэлд тань хамгийн тод үлдсэн мөч хэзээ байсан бэ?

Суралцагчид хоорондоо танилцаж, нэгнээ дэмжиж, нэг хамт олон болж байгааг харах хамгийн сайхан байсан. Ялангуяа спортын тэмцээний үеэр өөр өөр ангийн залуус богино хугацаанд гар нийлж, хамтарч ажиллахыг хараад бахархсан. Мөн “Grow with Google Challenge” төслийн хүрээнд суралцагчдын дэвшүүлсэн санаа, хийсэн судалгаа, илтгэлүүдийг хараад монгол залуусын сэтгэн бодох, суралцах, олон өнцгөөс асуудлыг харж шийдвэрлэдэг чадвараар нь үнэхээр бахархаж тэр мөчид бид улс эх орондоо ихийг хийж бүтээх боломж, хангалттай нөөц бололцоотой юм гэх бодол төрж их урам орсон доо.



672 цагийн танхимын хичээл

Онлайн сургалтыг практик орчноор дэмжих зорилгоор нийт 672 цагийн танхимын сургалт зохион байгуулсан байна. Суралцагчид воркшоп, багийн ажил, бодит кэйс дээр ажиллах туршлага хуримтлуулав.



43 коммьюнити арга хэмжээ

Зөөлөн ур чадвар, ажлын байраар зочлох, нетворкинг арга хэмжээ, Quiz Time зэрэг нийт 43 коммьюнити арга хэмжээ зохион байгуулагджээ. Эдгээр нь оролцогчид найз нөхөд, ажил олгогч, бизнес эрхлэгчдийн дунд хүрээллээ тэлж, тал бүрийн ур чадвараа нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлсэн.





Мод тарих өдөрлөг 2026

"HushKhan" брэндийн санаачилсан "ХУШ: Хангайн эзэн" мод тарих өдөрлөгийн хүрээнд "Grow with Google Mongolia" хөтөлбөрийн оролцогчид Богд Хан уулын аманд нийт 1,200 ширхэг хуш модны суулгац тарив. Энэхүү үйл ажиллагаа нь байгаль орчны тогтвортой байдлыг дэмжих, ойжуулалтын ажлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хамтын оролцооны бодит жишээ болж чадсан юм. Мөн өдөрлөгийн үеэр цахим спортын компьютер үйлдвэрлэгч "Allied Gaming" компанийн төлөөлөгчид залуустай хамт мод тарьж, байгаль орчноо хамгаалж, нөхөн сэргээх үйлсэд нэгдэж, олон улсын зах зээлд хуримтлуулсан туршлагаасаа хуваалцан, оролцогчидтой сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүлэв.



ТАНИЛЦАХ АРГА ХЭМЖЭЭ

"Grow with Google Mongolia" хөтөлбөрийн хүрээнд оролцогчдыг өөр хоорондоо танилцуулах, салбар хоорондын харилцаа холбоог тогтоох нетворкинг арга хэмжээнүүдийг үе шаттайгаар зохион байгуулав. Энэхүү чөлөөт уулзалтууд нь суралцагчдад туршлагаа хуваалцах, ирээдүйн хамтын ажиллагааны эхлэлийг тавих болон мэргэжлийн хүрээллээ тэлэх таатай талбар болсон юм.





КОММЬЮНИТИ АРГА ХЭМЖЭЭ: QUIZ TIME

“Grow with Google Mongolia” хөтөлбөрийн 2025-2026 оны элсэгчдийн дунд оюуны чадамж сорих, багийн ажиллагааг дэмжих “Quiz Time” нөхөрсөг тэмцээнийг зохион байгуулав. Энэхүү арга хэмжээ нь суралцагчдын харилцаа холбоог бэхжүүлэх, олж авсан мэдлэгээ бүтээлчээр бататгах, коммьюнитигийн идэвхтэй соёлыг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой болсон юм.





3 спортын тэмцээн

Хамт олны уур амьсгалыг дэмжиж, хүрээллийг бэхжүүлэх үүднээс гурван жил дараалан спортын тэмцээн зохион байгуулжээ.





Хамтрагч байгууллагын оффис аялал






“Grow with Google Challenge” төслийн уралдаан

Суралцагчдын идэвх, хамтын ажиллагаа, сурсан мэдлэгээ бодитоор хэрэгжүүлэх чадварыг дэмжих зорилгоор 3 удаа төслийн уралдаан зохион байгуулав. Нийт 30 гаруй баг төслийн санаагаа хөгжүүлэн өрсөлдөж, байр эзэлсэн төслүүд улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн судалгаа болон хөгжиж, зарим багууд төслийн концепцоо амжилттай стартап бизнес болгон өргөжүүлжээ.



“Challenge 2026” уралдааны оролцогчдын дунд AI технологийн хэрэглээ өндөр байв. 2025 оны хөтөлбөртэй харьцуулахад санаачилсан төслүүдийн бараг 70 орчим хувь нь хиймэл оюун ухааны тусламжтайгаар төслийн танилцуулгаа дараагийн шатанд гаргаж, шинэлэг байдлаар бэлтгэсэн байсан юм.





Зөөлөн ур чадварын сургалт

Техникийн мэдлэгээс гадна ажлын байранд амжилт гаргахад харилцаа, хамтын ажиллагаа, манлайлал, асуудал шийдвэрлэх сэтгэлгээ зэрэг зөөлөн ур чадварууд чухал үүрэгтэй. "Grow with Google Mongolia" хөтөлбөрийн хүрээнд оролцогчид гарааны бизнес, бүтээлч үйлдвэрлэл, карьерын чиг баримжаа зэрэг сэдвээр зохион байгуулагддаг сургалт, уулзалтуудад хамрагдаж, ажлын байранд шаардлагатай чадамжаа тасралтгүй бэхжүүлдэг.



GOOGLE CAREER CERTIFICATE

Хөтөлбөрийг амжилттай төгссөн оролцогч бүр
Google-ийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн
албан ёсны сертификат авдаг.



Төгсөлтийн арга хэмжээ





Төгсгөлийн үг

Сүүлийн жилүүдэд хөдөлмөрийн зах зээл, технологийн хөгжил, бизнесийн орчин маш хурдтай өөрчлөгдөж байна. Үүнтэй зэрэгцэн байгууллагуудын хэрэгцээ, ажил олгогчдын шаардлага, хувь хүний карьерын хөгжлийн чиглэл ч тасралтгүй хувьсаж байгаа нь боловсрол, ур чадварын хөтөлбөрүүдийг илүү уян хатан, илүү бодит хэрэгцээнд нийцсэн байх шаардлагыг бий болгож байгаа юм.

“Grow with Google Mongolia” хөтөлбөрийн гол онцлог нь энэхүү өөрчлөгдөж буй хэрэгцээг ойлгож, хувь хүний хөгжил болон бизнесийн шаардлагад нийцүүлэн хөтөлбөрөө тасралтгүй шинэчилж ирсэнд оршиж байна. Бидний зорилго тодорхой нэг ур чадвар заахаас гадна суралцагчдыг шинэ орчинд хурдан дасан зохицох, бие даан суралцах, өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх чадварт бэлтгэхэд чиглэж ирэв.

Өнгөрсөн гурван жилийн хугацаанд хөтөлбөрийн агуулга, сургалтын аргачлал, практик кэйсүүдийг хөдөлмөрийн зах зээл дэх эрэлттэй уялдуулан тогтмол шинэчилж, хиймэл оюун, автоматжуулалт, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт зэрэг ажлын байранд бүтээмж, оновчтой процессыг нэвтрүүлэх ач холбогдолтой агуулгаар баяжуулжээ. Энэ нь мэргэжлийн мэдлэг олгохоос гадна ирээдүйн ажлын байранд шаардлагатай хөрвөх чадвар, асуудал шийдвэрлэх сэтгэлгээ, дижитал орчинд ажиллах ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн юм.

Цаашид “Grow with Google Mongolia” хөтөлбөр илүү өргөжиж, хувьсан өөрчлөгдөж буй зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэшлийн чиглэлүүдийг нэвтрүүлэх, дэлхийн зах зээлтэй холбох, хөрвөх чадвартай мэргэжилтнүүдийг бэлтгэх зорилгоо үргэлжлүүлэн өргөжүүлэх болно. Түүнчлэн сургалтаас гадна тасралтгүй суралцах, мэдлэгээ хуваалцах, хамтдаа өсөж хөгжих хүрээллээ тэлэхийг чухалчилж байна.

Өнөөдөр тасралтгүй суралцах чадвар амьдралын хэв маягийн нэг хэсэг болж өөрчлөгдөж байгаа бөгөөд “Grow with Google Mongolia” хөтөлбөрийн хувьд энэхүү шинэ соёлыг түгээж, өөрчлөгдөж буй дэлхийд дасан зохицох чадвартай, илүү өрсөлдөхүйц, илүү итгэлтэй ирээдүйн боловсон хүчнийг бэлтгэхэд хувь нэмрээ оруулсаар байх болно.

Mongolia Grow with Google

Холбоо барих:

 [Grow with Google Mongolia](#)

 [gwg.mongolia](#)

 Info@gwg.mn

